Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

**Swiss Agency for Development and Cooperation SDC**
**Швейцарын хөгжлийн агентлаг**

# Монгол Улсад хэрэгжүүлэх Швейцарын Хамтын ажиллагааны стратеги

2018 - 2021






# Товчилсон үгс

| | |
|---|---|
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| БАГ | Бэлчээр ашиглалтын гэрээ |
| БАХ | Бэлчээр ашиглагчдын хэсэг |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| БСШУСЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| ГОУХАН | Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг |
| ДБГ | Дэлхийн Банкны групп |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЖГҮ | Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ |
| ЖСХТТ | Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл |
| ЗГҮАХ | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр |
| ЗГХЭГ | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЗХЭДТ | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл |
| ИНБ | Иргэний нийгмийн байгууллага |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МБС | Мэргэжлийн боловсрол, сургалт |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| МУНЭХБТ | Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөл |
| МУЧХТ | Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх төсөл |
| МСҮТ | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв |
| НЖШҮ | Нэгдсэн жишиг шалгуур үзүүлэлтүүд |
| НҮБ | Нэгдсэн Үндэсний Байгууллага |
| НҮБХАС | НҮБ-ын Хүн амын сан |
| НҮБХХ | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр |
| НЦҮ | Нэг цонхны үйлчилгээ |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОУВС | Олон Улсын Валютын Сан |
| ОУСБ | Олон Улсын Санхүүгийн Байгууллага |
| ОУХБ | Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| СБМС | Суурь боловсрол, мэргэжлийн сургалт |
| СЯ | Сангийн яам |
| УИХ | Улсын Их Хурал |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТББТ | Төлөөллийн байгуулагыг бэхжүүлэх төсөл |
| ТБУТ | Тогтвортой бичил уурхай төсөл |
| ТМБС | Техник мэргэжлийн боловсрол, сургалт |
| ТХБ | Тогтвортой хөгжлийн боловсрол |
| ТХЗ | Тогтвортой хөгжлийн зорилтууд |
| ТХҮБ | Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 |
| ҮСГ | Үндэсний статистикийн газар |
| ХБНГУ | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс |
| ХЗДХЯ | Хууль зүй, дотоодын хэргийн яам |
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ХХҮЕГ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар |
| ЦУОШГ | Цаг уур, орчны шинжилгээний газар |
| Шв.франк | Швейцар франк |
| ШХА | Швейцарын хөгжлийн агентлаг |
| ШХАГ | Швейцарын хамтын ажиллагааны газар |
| ШХАС | Швейцарын хамтын ажиллагааны стратеги |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |

# Гарчиг

**Товчилсон үгс** 2

**Өмнөх үг** 5

**Хураангуй** 6

**1. Өнөөгийн нөхцөл байдал** 8

**2. Швейцарын гадаад бодлого** 11

**3. Швейцарын хамтын ажиллагааны үр дүн** 12
Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал 12
Мэргэжлийн боловсрол, сургалт 13
Засаглалын шинэтгэл, орон нутгийн засаглал ба иргэний оролцоо 14
Тогтвортой бичил уурхай төсөл 15

**4. Үйл ажиллагааны чиглэлд орж буй өөрчлөлт** 16

**5. Тэргүүлэх чиглэл ба зорилтууд** 17
Үндсэн чиглэл 1: Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал 17
Үндсэн чиглэл 2: Суурь боловсрол ба мэргэжлийн сургалт 18
Үндсэн чиглэл 3: Засаглал 18
Нийтлэг сэдвүүд: Жендэр ба засаглал 19

**6. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх менежмент** 20
Түншүүд 20
Швейцарын хөгжлийн агентлагийн хөтөлбөрт орж буй өөрчлөлт 20
Санхүүжилт 21

**7. Стратегийн удирдлага** 22

**Хавсралт 1: Хамтын ажиллагааны стратегийн товчоон** 23

**Хавсралт 2: Үндсэн чиглэлүүдийн үр дүнгийн хүрээ** 24

**Хавсралт 3: Үзүүлэлтүүдийн тайлбар** 33

**Хавсралт 4: Хяналт үнэлгээний систем** 39

**Хавсралт 5: Санхүүгийн төлөвлөлт** 40

**Хавсралт 6: Нэр томъёо** 41

**Хавсралт 7: Монгол Улсын газрын зураг** 42



# Өмнөх үг

Швейцар, Монгол хоёр орны дипломат харилцаа 1964 оноос эхэлсэн түүхтэй. Тэр цагаас хойш Монгол Улс нь улс төр, нийгэм, эдийн засгийн шилжилтийг туулж, эдгээр чиглэлд томоохон өөрчлөлтүүдийг хийгээд байна. 1990 оны ардчилсан хувьсгалын дараа сонгосон олон намын ардчилсан тогтолцоо нь өнөөг хүртэл харьцангуй тогтвортой болох нь нотлогдлоо. Мөн чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэн, уул уурхай эрчимтэй хөгжсөн нь төдийлөн тэнцвэртэй, тогтвортой байж чадахгүй байгаа ч урьд хожид байгаагүй эдийн засгийн өсөлт, төсвийн орлогыг бий болгосон юм. Ийнхүү Монгол Улс ололт амжилтаа улам бататган хөгжүүлж, урт хугацаанд тогтвортой байдлаа хадгалахыг эрмэлзэж байна.

Монгол Улсад зудын гамшиг нүүрлэж 10 гаруй сая мал хорогдон, малчид болон малчин өрхийн нийгэм, эдийн засгийн байдалд ноцтой хүндрэл учирсан 2001 онд Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА) гамшигт нэрвэгдсэн малчдад хүмүүнлэгийн тусламж үзүүлж эхэлсэн тэр үеэс Швейцар Улс тус улсын хөгжил дэвшлийг дэмжиж ирсэн билээ. 2004 онд ШХА нь Хамтын ажиллагааны газраа Улаанбаатар хотноо нээж, Дунд хугацааны хамтын ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд бэлчээрийн тогтвортой менежментийг нэвтрүүлэх замаар тухайн салбарын хувьд тулгамдаж байсан сорилт бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэхийг зорьж байв. 2007-2012 онуудад хэрэгжүүлсэн Швейцарын хамтын ажиллагааны анхны стратеги нь байгалийн баялгийн тогтвортой удирдлага, хөдөлмөр эрхлэлт, иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд голлон анхаарч байлаа. Монгол Улсын Үндэсний хөгжлийн бодлогод тулгуурлан боловсруулж, 2013 - 2017 онд хэрэгжүүлсэн удаах стратеги нь тус улсад тулгамдаж буй хэд хэдэн гол асуудалд анхаарахын хамт өөрийн орны хувьд хуримтлуулсан мэдлэг туршлагаас хуваалцах засаглалын шинэтгэл, нутгийн удирдлага, иргэний оролцооны үндсэн чиглэлийг нэмж оруулсан билээ.

Ийнхүү 15 орчим жилийн турш чин сэтгэлээс хэрэгжүүлсэн нягт хамтын ажиллагааны түүхийг эргэн харахад ШХА, Монголын хөгжлийн хамтын ажиллагаа ихээхэн амжилттай төдийгүй Монгол Улсын хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлсэн бодитой үр дүн арвин байна.

Сүүлийн жилүүдэд хөгжлийн нааштай үр дүн гарч байгаа ч Монгол Улсын өмнө томоохон сорилт, бэрхшээлүүд тулгарсаар байна. Үүнд хотжилт ихээхэн эрчимжиж, ажлын байрны хомсдол үүсч, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө нэмэгдэх болсон, мөн тогтворгүй, тэнцвэргүй эдийн засаг зэргийг дурдаж болно. Харин эрдэс баялгийн нөөцөө зөв зохистой, үр дүнтэй ашиглаж чадвал дэд бүтцээ шинэчлэх, төрөөс иргэдэд үзүүлэх суурь үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хотжилтоос үүдэлтэй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах зэрэг бодлого хэрэгжүүлэх боломжууд бий болох юм. Байгалийн баялгийн орлогыг ил тод удирдлагаар хангах чиглэлд сайн засаглалыг дэмжиж, улс төрийн хүрээний орчин нөхцлийг сайжруулах нь урт хугацааны тогтвортой байдлыг хангахад шийдвэрлэх хүчин зүйл мөн.

Ийнхүү эрчимтэй өөрчлөлт, шинэчлэлт хийх улс төрийн хүсэл зоригтоо тулгуурлан бэрхшээл сорилтыг даван туулахыг зорьж буй Монгол Улсын хүчин чармайлтыг Швейцар Улс тууштай дэмжих болно. Энэхүү Хамтын ажиллагааны стратеги нь тус улсын хөгжилд Швейцар Улсын ирэх дөрвөн жилийн хугацаанд үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох бөгөөд хөдөө аж ахуй ба хүнсний аюулгүй байдал, мэргэжлийн боловсрол, сургалт, засаглал гэсэн үндсэн чиглэлд төвлөрч байна. Мөн энэ стратеги нь ихээхэн өөрчлөгдөж буй өнөөгийн хөгжлийн нөхцлийг харгалзан үзсэн бөгөөд түүнтэй уялдуулан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх арга хэлбэрийг оновчтой шийдэж, Швейцар, Монголын цаашдын хамтын ажиллагааг өөрчлөх үндэс суурийг тавьж өгөх юм.



ШХА-ийн Ерөнхий захирал, Элчин сайд
Мануэл Загер

# Хураангуй

Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал ерөнхийдөө эерэг байгаа хэдий ч хөгжлийн хэд хэдэн харилцан хамаарал бүхий сорилт бэрхшээл тулгарсаар байна. 2013 он хүртэл үргэлжилсэн уул уурхайн салбарын их өсөлтийн үр дүнд тус улс ядуурлыг бууруулахад үсрэнгүй ахиц дэвшил гаргасан ч энэ нь тогтвортой хадгалагдаж чадсангүй. Эдийн засгийн уналтын улмаас 2014 онд 21.6 хувь байсан ядуурлын түвшин 2016 онд 29.6 хувь болж өсчээ. Нэг салбараас хэт хараат болсон төрөлжилт муутай эдийн засаг тус улсыг олон улсын бараа, түүхий эдийн зах зээлээс хамааралтай болгож, энэ нь бусад олон салбарт сөрөг үр дагаврыг бий болгож байна. Цаашлаад засаглалын томоохон алдаа дутагдлууд бугшсаар байгаа учир цаашид шинэ тулгар ардчиллыг бататган бэхжүүлэх шаардлагатай байна. Байгалийн баялгаас хэт хамаарсан байдал хэвээр байсаар байна. Уур амьсгалын өөрчлөлт, эрчимтэй хотжилтын сөрөг нөлөөгөөр ядууралтай тэмцэх хүчин чармайлтад шинэ шинэ сорилт бэрхшээлүүд тулгарч байна.

Швейцар, Монгол хоёр улсын харилцаа 1964 оноос эхэлсэн түүхтэй. ШХА анх 2001 онд зудын гамшигт нэрвэгдсэн малчдад туслах зорилгоор хүмүүнлэгийн хөтөлбөрөө Монголд хэрэгжүүлж эхэлсэн. Улмаар, 2004 оноос хойш хүмүүнлэгийн хөтөлбөрөө хөгжлийн хөтөлбөр болгон өргөжүүлсэн юм. Швейцарын хөгжлийн хөтөлбөрүүд цар хүрээгээ тэлсээр 2013 - 2017 онд хэрэгжүүлсэн өмнөх стратегийн үед хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал, мэргэжлийн боловсрол, сургалт, засаглалын шинэтгэл, нутгийн удирдлага, иргэний оролцоо гэсэн чиглэлүүдийг хамрах болсон.

2013 - 2017 оны Хамтын ажиллагааны стратегийн хүрээнд хэрэгжүүлсэн Швейцарын хөтөлбөр үр дүнтэй байлаа. Стратегийн үндсэн зорилго нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах явдал байв. Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын чиглэлд шинэлэг арга барилаар тогтвортой хөрөнгө оруулалт хийснээр малчид, тариаланчдын амьжиргаа дээшилж, Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт ШХА-ийн үзүүлсэн туслалцаа тус улсын мэргэжлийн боловсролын чанар, салбарын нэр хүндийг сайжруулж, хөдөөгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэх боломжийг дээшлүүлсэн билээ. Мөн орон нутгийн засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлснээр шийдвэр гаргах үйл явцад оролцох иргэдийн оролцоо, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэхэд хувь нэмрээ оруулж, энэ чиглэлийн тэргүүлэх хандивлагч болсон юм.

2018 - 2021 оны Швейцарын Хамтын ажиллагааны стратегиийн хүрээнд эдгээр үр дүн, тэргүүн туршлагыг бататган, Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал, Суурь боловсрол ба мэргэжлийн сургалт, Засаглал гэсэн гурван үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхээр шийдвэрлэлээ. 2018 - 2021 оны Швейцарын Хамтын ажиллагааны стратегийн эрхэм зорилго бол иргэн бүрт хүртээмжтэй, эрх тэгш, ногоон, хөгжингүй нийгмийг байгуулах Монгол Улсын иргэд, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах явдал юм. Энэ зорилгод хүрэхийн тулд Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хөдөөгийн болон хот орчмын өрхийн аж ахуй эрхлэж буй тариаланчид, малчдын эмзэг бүлгийн амьжиргааг дээшлүүлэх, Суурь боловсрол, мэргэжлийн сургалтын чиглэлээр иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, Засаглалын чиглэлээр төр засаг, орон нутгийн засаг захиргааны хариуцлагатай, үр нөлөөтэй байдлыг хөхиүлэн дэмжиж, иргэний нийгмийг бэхжүүлэх зорилт тавьж ажиллана. Уг стратегид нийцүүлэн ШХА-ийн бүхий л төсөл хөтөлбөрт жендэрийн тэгш байдал, засаглалын уялдааг хангана. Энэхүү Хамтын ажиллагааны стратеги нь 2017 - 2021 оны Швейцарын Холбооны Зөвлөлийн Олон улсын хамтын ажиллагааны чиглэлээр баримтлах бодлогын ерөнхий зорилго, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдтэй нийцсэн болно.

Хувьсан өөрчлөгдөж буй хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал, Монгол Улсын эдийн засгийн чадавх сайжирсан, мөн үйл ажиллагааны төсөв багасах төлөвтэй зэргээс үүдэн энэхүү стратеги нь 2021 оноос цааших хугацаанд Швейцарын хөгжлийн агентлаг Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ хэрхэн өөрчлөх, улмаар Дундаас дээш

орлоготой олон оронд нийтлэг тохиолддог шинэ нөхцөл байдалд зохицон уялдуулах зэрэгт бэлтгэх юм. Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын үндсэн чиглэл нь хөдөөд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх хүндрэлийг шийдвэрлэхэд чиглэн өөрчлөгдөнө. Суурь боловсрол, мэргэжлийн сургалтын үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийг 2018 - 2021 онд хэрэгжүүлж дуусгана. Засаглалын үндсэн чиглэлд тэргүүлэх ач холбогдол өгч, ил тод, хариуцлагатай, иргэдэд ээлтэй төрийн байгууллагатай болох нь улс орны нөөц баялгийн үр шимийг нийт иргэдэд эрх тэгш хуваарилах нэг чухал урьдач нөхцөл гэж үзнэ. ШХА-аас хот хөдөөгийн уялдаа холбоог харгалзан үзэж хотжилттой холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагаагаа эрчимжүүлнэ.

Тогтвортой байдал, институцжүүлэлтийг хангахын тулд ШХА-аас үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй нягт уялдуулан, төр засаг, иргэний нийгмийн салбарын түншүүдийнхээ чадавхыг бэхжүүлэх, бодлогын яриа хэлэлцээг өрнүүлэх, төр засгийн байгууллагуудын хамтын санхүүжилтийг нэмэгдүүлэх зэрэгт голлон анхаарна. 2021 оноос цааших ШХА-ийн Монгол дахь хөтөлбөрийн хамтын ажиллагааны арга хэлбэрийг техникийн туслалцаа, мэдлэг түгээх зэрэгт илүүтэй чиглүүлнэ. Түүнчлэн ШХА-аас гурван талт хамтын ажиллагааны төслүүдээр дамжуулан хувийн хэвшилтэй хамтран ажиллах, ШХА-ийн Дэлхийн нийтийн хөтөлбөрүүдийн туршлага, ноу-хауг авч ашиглах боломжийг эрэлхийлнэ.

Энэ хугацаанд хөтөлбөрийн нийт төсөв 51.5 сая шв.франк байхаар төлөвлөж байна. Жилийн төсвийн хэмжээ 2018 онд 13.5 сая шв.франк байх бол 2021 онд 12 сая шв.франк болж буурах юм.

# 1. Өнөөгийн нөхцөл байдал

Монгол орон нь хойд талдаа ОХУ, урд талаараа БНХАУ гэсэн хүчирхэг хоёр хөрштэй хил залган оршдог далайд гарцгүй, уудам том газар нутагтай, 3 сая гаруйхан хүн амтай. Мөн эрс тэс уур амьсгал, хүн амын нягтшил (нэг ам дөрвөлжин километр тутамд хоёр хүн), хүн амын жигд бус тархалтаараа ихээхэн өвөрмөц онцлогтой улс. Хөдөө орон нутагт хүн амын нягтшил маш сийрэг байдаг бол нийслэл Улаанбаатар хотод бараг 1.5 сая хүн оршин суудаг. Нийслэл хотын хүн ам сүүлийн 20 жилд 70 хувь өссөн бөгөөд үүний талаас илүү хувь нь орон нутгаас шилжин ирж суурьшсан байна.

Тус улсын эдийн засаг 2009 - 2013 онд урьд өмнө байгаагүйгээр огцом өсч, энэ өсөлтийн хувь нь хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж байсан ч эргээд уналтад орсон (2016 онд 1 хувь болсон). Энэхүү савалгаа нь үндсэндээ байгалийн баялагт түшиглэсэн, төрөлжиж чадаагүй эдийн засагтай холбоотой. Иймээс олон улсын түүхий эдийн зах зээлийн өөрчлөлтөөс шууд хамааралтай байдаг. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж нь огцом өсөлт, уналтын мөчлөгийг тэнцвэржүүлэхийг зорьдог боловч эдийн засгийн их өсөлтийн үед үүнийг хангалттай зохицуулж чадаагүйгээс төсвийн зарцуулалтын хэтрэлт, төсвийн алдагдал, улсын өрийн түвшин нэмэгдэхэд хүрсэн билээ. Макро эдийн засгийн энэ хямрал нь бодлогын шинэтгэлийн хатуу болзол бүхий ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг гурван жилийн хугацаатай хэрэгжүүлэхэд хүргэсэн юм. Монгол Улс зэс, алт, нүүрс болон бусад ашигт малтмалын томоохон ордуудынхаа ачаар эдийн засгийн ерөнхий төлвийн хувьд эерэг хэвээр байгаа ч эдгээр асуудлыг шийдвэрлэхэд улс төрийн шинэтгэл хийх, төсвийн сахилга батыг чангатгах асуудал хойшлуулшгүй чухлаар тавигдаж байна. Мөн эдийн засгийн өсөлтийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татахын тулд тогтвортой, олон талт үндэс суурийг бүрдүүлэх явдал нэн чухал байна.

Монгол Улсын 1992 оны ардчилсан Үндсэн хууль олон намын тогтолцоо, зах зээлийн эдийн засаг, хүний эрхийг дээдлэн хамгаалахыг хуульчилснаар ардчилалд шилжих шилжилтийг амжилттай чиглүүлж өгсөн юм. Засгийн эрх тайван замаар хэд хэдэн удаа Монгол Ардын Нам, Ардчилсан Намын хооронд шилжсэн. Ардчилсан



институцийг байгуулж чадсан ч засаглалын алдаа дутагдлууд бугшсан хэвээр байгаа нь энэхүү харьцангуй залуу ардчиллыг улам бүр бэхжүүлэх шаардлага байгааг харуулж байна. Хуулийн хэрэгжилт хангалтгүй, авлига газар авсан нь иргэдийн төр засаг, улс төрийн намуудад итгэх итгэлийг алдагдуулж байна. Улс төрийн ба иргэний эрх ерөнхийдөө хангагдаж чадаж буй бөгөөд дотоод, гадаадын хүний эрхийн олон бүлгүүд төр засгийн аливаа хязгаарлалтгүйгээр ажиллаж байна. Хэвлэл мэдээллийн салбар харьцангуй чөлөөтэй боловч улс төрийн ашиг сонирхлоос хараат бус байж, гүнзгий дүн шинжилгээ хийх чадвар дутагдалтай байна. 2016 онд болсон парламентын сонгуулийн үр дүнд төрийн эрх мэдэл шилжсэний дараа засгийн газрын тэргүүлэх чиглэлд томоохон өөрчлөлт ороогүй боловч төрийн албаны тогтворгүй, улс төржсөн байдал нь институцийн залгамж чанар алдагдаж, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад саад учруулсаар байна. Сүүлийн жилүүдэд хийсэн шинэчлэлийн явцад төвлөрлийг сааруулах, шүүхийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлд нилээд ахиц дэвшил гарсан юм.

Гадаад бодлогын хувьд 1990 оноос хойш Монгол Улс хоёр хөршөөсөө бусад улстай хоёр талт болон олон талт дипломат харилцааг хөгжүүлэх үүднээс “гуравдагч хөршийн бодлого” баримталж ирсэн. Тус улс олон улсын тавцанд төдийгүй олон талт байгууллагуудын хүрээнд идэвхтэй байж, бүс нутагтаа, нэн ялангуяа Солонгосын хойгийн асуудалд зуучлагчийн үүрэг гүйцэтгэхийг эрмэлзэх болжээ. Монгол Улс Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Ази, Европын уулзалт гэх мэт бүс нутгийн байгууллагын гишүүн бөгөөд Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад ажиглагчийн статустай оролцдог.

Сүүлийн жилүүдэд Монгол Улс ядуурлын түвшинг бодитойгоор бууруулж чадсан нь гол төлөв эдийн засгийн их өсөлт, нийтийг хамарсан нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн үр дүн байлаа. Улсын хэмжээнд амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой амьдарч буй иргэдийн албан ёсны тоо 2010 онд 38.8 хувь байсан бол 2014 онд 21.6 хувь болж буурчээ. Харин энэ ахиц дэвшил харьцангуй хэврэг байсан нь эдийн засгийн уналтын улмаас ядуурал 2016 онд эрс нэмэгдэж 29.6 хувь хүрснээс харагдаж байна. Хөдөөгийн ядуурлын түвшин (34.9 хувь) хот суурин газрынхаас (27.1 хувь) илүү өндөр байна. Гэвч хотжих үйл явц эрчимжиж, нийт ядуу иргэдийн дийлэнх нь цэвэр ус, бохир усны систем, төвлөрсөн халаалт, цахилгаан эрчим хүчний хангамж зэрэг төрийн үндсэн үйлчилгээний хүртээмж муутай хот суурин газар, хотын захын хорооллууд, ялангуяа Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн гэр хороололд амьдардаг. Тэгш бус байдал нэмэгдэж байна гэж олон нийт үзэж байна. Монголын хүн амын хамгийн баян 20 хувь үндэсний нийт хэрэглээний 40 хувийг бүрдүүлж байхад, хамгийн ядуу 20 хувь нь дөнгөж долоон хувийг хэрэглэж байна. Өнөөгийн эдийн засгийн уналт нь энэхүү тэгш бус байдлыг улам нэмэгдүүлж, ядуус, эмзэг бүлгийн иргэдэд улам сөргөөр нөлөөлж болох юм.

Боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах шаардлагатай байна. Бичиг үсэг тайлагдалтын түвшин 97 хувь байгаа ч боловсролын чанар тааруу байна. Боловсролын хүртээмжийн тэгш бус байдал байсаар байгаа нь ялангуяа хөдөөгийн болон хотын захын оршин суугчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургуулийн өмнөх боловсролын салбарт илэрхий байна. Эрүүл мэндийн салбарт хөдөөгийн хүн амын тархан суурьшилтын улмаас алслагдмал нутагт эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй байдаг бол хот суурин газрын эмнэлгүүдийн ачаалал хүн амын өсөлтийнхөө хурдыг гүйцэхгүй байна. Хүн амын дундаж наслалтын түвшин доогуур хэвээр (улсын дундаж 69.89 нас, эрэгтэйчүүд 66 нас, эмэгтэйчүүд 74 нас), зүрх судасны өвчин, хорт хавдар гэх мэт халдварт бус өвчний тархалт олон улсын дунджаас хавьгүй өндөр байна. Хөдөөд болон Улаанбаатар хотын гэр хороололд ундны усны хүртээмж дутмаг, оршин суугчдын 60 хувь нь ус түгээх цэг буюу худгаар үйлчлүүлж байна. Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн ашиглалт хот суурин газарт 64 хувь, хөдөө орон нутагт 53 хувь байна.

Монгол Улс жендэрийн тэгш бус байдлын индексээр 188 орноос 53-т эрэмбэлэгддэг. Эмэгтэйчүүд ерөнхийдөө адил тэгш боломж эдэлдэг боловч тэдний улс төрийн

оролцоо, жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх асуудал хурцаар тавигдсаар байна. Эмэгтэйчүүд харьцангуй өндөр боловсролтой, мэргэжлийн ажиллах хүчний дийлэнхийг эзэлдэг боловч төр засгийн болон хувийн хэвшлийн удирдах албан тушаалд тэдний төлөөлөл бага. УИХ-ын 76 гишүүний 13 нь л эмэгтэй гишүүд байна. Хот, хөдөө ялгаагүй нийгмийн бүхий л хүрээнд гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл их байна. Мөн цалин хөлсний ялгавартай байдал ч байсаар байна. Хөдөөгийн эрэгтэйчүүд мал маллахын тулд сургуулиа эрт орхидог учраас боловсролын түвшний хувьд эмэгтэйчүүдээс харьцангуй доогуур байдаг.

Монгол бол уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөмтгий орны нэг. 1940 оноос хойш Монгол орны агаарын дундаж хэм цельсийн 2.1 хэмээр нэмэгдсэн нь дэлхийн дундаж үзүүлэлтээс даруй хоёр дахин их байна. Сүүлийн жилүүдэд зудын давтамж олширч, олон сая мал хорогдсоны улмаас малчин өрхүүдийн амьжиргааны түвшин буурахад хүргэж байна. Уур амьсгалын өөрчлөлт бэлчээрийн даац хэтрэлттэй хосолсон нь бэлчээр доройтолд орох үндсэн шалтгаан бөгөөд Монгол орны бэлчээрийн нутгийн 65 хувь нь тодорхой хувиар доройтсон байна. Усны хомсдол нэмэгдэж, 2030 он гэхэд усны хэрэглээ нь байгаа нөөцөөсөө хэтрэх төлөвтэй байна. Аймгийн төвүүд болон Улаанбаатар хотын гэр хорооллын өрхүүд гэр орноо хангалттай дулаалж чадахгүй, улмаар түүхий нүүрс ихээр түлж байгаагаас, мөн автомашины хөдөлгөөнөөс үүдсэн утаа агаарын бохирдлыг нэмэгдүүлснээр дэлхийн хамгийн их бохирдолтой хэмжээнд хүргээд байгаа нь нийтийн эрүүл мэндэд ч ихээхэн сөргөөр нөлөөлж байна. Агаарын бохирдол нь амьсгалын замын болон зүрх судасны өвчин, улмаар эрт нас баралтын шалтгаан болоод зогсохгүй уур амьсгалын өөрчлөлтийн нэгэн адилаар эдийн засагт асар их хор хохирол учруулдаг. Түүнчлэн усны бохирдол, бохир ус зайлуулах байгууламж хүрэлцээгүй байх зэрэг бусад хүндрэл бэрхшээл ч бий.

2016 онд Монгол Улсын Их Хурлаас "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (ТХҮБ) 2030"-ыг баталсан бөгөөд тогтвортой хөгжлийн зорилтуудыг өөрийн орны нөхцөлд тохируулан гаргасан энэхүү баримт бичиг цаашид ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжилд хүрэх хүчин чармайлтыг чиглүүлж өгөх юм. Цаашлаад уг үзэл баримтлалын зорилтуудыг Засгийн газрын 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бөгөөд хандивлагчид ч хамтын ажиллагааны стратегиа эдгээр бодлогын чухал баримт бичгүүдэд нийцүүлэн ажиллаж байна.

# 2. Швейцарын гадаад бодлого

Швейцарын хөгжлийн агентлаг (ШХА) бол Монгол дахь Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааг төлөөлөгч Холбооны засгийн газрын албан ёсны агентлаг юм. ШХА 2001 оны зудын гамшигт нэрвэгдсэн малчдад туслах хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрөөр Монголд анх үйл ажиллагаагаа эхэлсэн. ШХА хүмүүнлэгийн хөтөлбөрөө хөгжлийн хөтөлбөр болгон өргөжүүлсэнтэй холбоотойгоор 2004 онд Хамтын ажиллагааны газраа Улаанбаатар хотноо нээсэн билээ. Анх байгалийн нөөцийн тогтвортой менежмэнт, хөдөө аж ахуйн хөгжил, хүнсний аюулгүй байдалд голлон чиглэж байв. Улмаар хөтөлбөрийн хамрах хүрээ өргөжиж, Мэргэжлийн боловсрол, сургалт, Засаглалын чиглэлүүдийг хамрах болсон.

Монгол, Швейцарын найрсаг дипломат харилцаа 1964 оноос эхтэй. Хоёр улс нийтлэг ардчилсан үнэт зүйлсийг эрхэмлэхийн зэрэгцээ өндөр, дээд түвшний улс төрийн харилцан айлчлал тогтмол хийгдэж байна. Олон талт хамтын ажиллагааны хүрээнд ч Монгол Улс үзэл санаа нэгтэй орны нэг бөгөөд тодорхой чиглэлүүдийн хамтын ажиллагааны түнш юм. Хоёр орны эдийн засгийн харилцаа хязгаарлагдмал, Монголд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Швейцарын компани цөөхөн.

Монгол дахь Швейцарын Хамтын ажиллагааны стратеги нь 2017 - 2021 оны Швейцарын Холбооны Зөвлөлийн Олон улсын хамтын ажиллагааны талаар баримтлах бодлого, түүний стратегийн зорилтуудад нийцэж байна. Уг баримт бичигт Монгол Улсыг Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны тэргүүлэх улсуудын нэг хэмээн тодорхойлсон. Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал, Суурь боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалт, Засаглал гэсэн хөтөлбөрийн гурван үндсэн чиглэл ч Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй нийцэж байна. Эдгээр салбарыг Швейцар улсын онцлог, давуу тал, сайн туршлага, үнэт зүйлсийг харгалзан үзэж сонгосон болно.

Тус улсын нөөц баялаг, ядуурлыг бууруулахад гаргасан ололт амжилт, мөн ШХА-ийн Дунд орлоготой орнуудад үзүүлэх хөтөлбөрөө эргэн хэлэлцэж буй нөхцөл байдалтай уялдуулан энэхүү Хамтын ажиллагааны стратеги нь цаашид Монгол дахь Швейцарын хамтын ажиллагааг өөрчлөн шинэчлэх үндэс суурь болох юм. Энэхүү шилжилтийн үед өнөөг хүртэл хэрэгжүүлэн үр дүнгийн тогтвортой байдлыг хангах, институцчилэлийг бэхжүүлэх, одоогийн төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг нэгтгэхэд бүх анхаарлаа хандуулна. Үүний зэрэгцээ 2021 оноос хойш харьцангуй бага төсөвтэйгээр, шинэ арга хэлбэрээр хамтран ажиллах эсвэл хөтөлбөрийг аажмаар дуусгах асуудал яригдах боломжтой. Шийдвэрийг Швейцарын Олон улсын хамтын ажиллагааны дараагийн бодлогод нийцүүлэн 2019 онд гаргах болно. Санхүүжилтийн хувьд Монгол дахь Швейцарын хөгжлийн тусламжийн хэмжээ 2018 - 2021 онд жилд 13.5 саяас 12 сая шв.франк орчим болно.

ШХА үйл ажиллагаагаа бусад хандивлагчидтай идэвхтэй уялдуулж хамтран ажиллаж, хүчин чармайлтаа нэгтгэхийг хөхиүлэн дэмжиж байна. Монголд АХБ, Дэлхийн банк, НҮБ-ын ихэнх төрөлжсөн байгууллагууд ажиллаж байна. Түүнчлэн ХБНГУ, Европын Холбоо, Япон, Өмнөд Солонгос зэрэг хоёр талын харилцааны томоохон хандивлагчид бий.



# 3. Швейцарын хамтын ажиллагааны үр дүн

Монгол дахь Швейцарын хөгжлийн агентлаг төр засгийн байгууллагууд, төслийн үр шимийг хүртэгчид, олон улсын болон хандивлагч байгууллагуудын дунд нэр хүнд сайтай байдаг. Ялангуяа сонгосон салбар болон бүс нутагтаа идэвхтэй ажиллаж, бүтээлч шинэлэг төсөл хөтөлбөрийг урт хугацаанд амжилттай хэрэгжүүлж бодитой эерэг өөрчлөлт бий болгож, үүний үр дүнд Швейцар улс Монгол дахь хөгжлийн гол түншийн нэг гэж хүлээн зөвшөөрөгдөөд байна.

2013 - 2016/17 оны Хамтын ажиллагааны стратегийнхаа хүрээнд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой, эрх тэгш хөгжилд хувь нэмэр оруулахыг эрхэм зорилгоо болгон ажилласан. Энэ үеэр Швейцарын дэмжлэг Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал, Мэргэжлийн боловсрол, сургалт, Засаглалын шинэтгэл, нутгийн удирдлага, иргэний оролцоо гэсэн гурван үндсэн чиглэлд анхаарч байлаа. Мөн бичил уурхайг дэмжих тусгай хөтөлбөр ч Хамтын ажиллагааны стратегийн нэг хэсэг байв. Энэхүү таван жилийн хугацаатай хөтөлбөрийн нийт төсөв 92 сая шв.франк хүрсэн байна.

**Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал**

ШХА хөдөө аж ахуйн салбарыг бэхжүүлэх төслүүд хэрэгжүүлснээр Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд хувь нэмрээ оруулсан. Ургац сайтай, эрт болцтой төмсний шинэ сортууд нэвтрүүлж дотоодын үр үржүүлэх тогтолцоог хөгжүүлсний ачаар тус улсын төмсний үйлдвэрлэл дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг боллоо. Энэ аргачлалаа хүнсний ногооны салбарт давтан хэрэгжүүлсний эерэг үр дүнгүүд ч гарч эхэлж байна. Хүнсний ногооны шинэ нутагшуулсан сортуудыг нэвтрүүлснээр дотоодын үр үйлдвэрлэл хоёр дахин нэмэгдлээ.

Бэлчээр хамгаалах, малчдын амьжиргааг дээшлүүлэх зорилгоор ШХА-аас 21 аймгийн 11 аймагт 42,000 гаруй малчдыг хамарсан 1,300 бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ) зохион байгуулагдахад дэмжлэг үзүүллээ. БАХ нь бэлчээрийн тогтвортой менежментийг нэвтрүүлэх, бичил санхүүгийн систем бий болгох, малчдыг түүхий эд боловсруулах үйлдвэрүүдтэй холбох, өвөлжилтийн бэлтгэлийг сайжруулах зэрэг институцийн чухал чиг үүргийг гүйцэтгэж байгаа нь малчдын амьжиргааг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.



Улсын хэмжээнд бэлчээрийн төлөв байдал, доройтлыг хянах шинжлэх ухааны үндэстэй бэлчээрийн мониторингийн системийг нэвтрүүлэн ашиглаж байна. Малчид, орон нутгийн захиргааны хооронд бэлчээр ашиглалтын 700 гаруй гэрээ байгуулагдаж малчдын уламжлалт бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулж, бэлчээрийн тогтвортой менежментийн арга барил нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлж байна. Түүнчлэн нөлөөллийн үйл ажиллагаа, бодлогын яриа хэлэлцээр идэвхтэй явуулсны үр дүнд бодлого боловсруулагчид бэлчээр хамгаалах тухай хуулийн төсөлд бэлчээр ашиглалтын зохион байгуулалт, бэлчээр ашиглалтын гэрээ байгуулахын сайн туршлага, аргачлалыг тусгасан.

Бэлчээр ашиглагчдын хэсэгт суурилсан малчдын 70 гаруй хоршоонд тэмээний ноос, сарлагийн хөөвөр зэрэг түүхий эдээ хамтран борлуулж, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүллээ. Малчдын хоршоодыг түүхий эд боловсруулах үйлдвэрүүдтэй урт хугацааны түншлэл бий болгоход нь дэмжлэг үзүүлэв. Мөн ШХА-аас малын даатгалын тогтолцоо нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлж, малаа даатгуулж зудын хохирлоос хамгаалах боломжийг нийт малчдад олголоо.

Малын гаралтай зарим халдварт өвчнийг (шүлхий, бруцеллёз) хянах шинэ стратеги нэвтрүүллээ. Олон улсын стандартад нийцсэн Малын эрүүл мэндийн тухай шинэ хуулийн төсөл боловсруулахад ШХА чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэхүү хууль 2017 оны 12 сард УИХ-аар батлагдлаа. Энэхүү шинэ хууль болон малын эрүүл мэндийн системийн шинэчлэл нь Монгол Улс малын гаралтай бүтээгдэхүүнээ Хятад, Орос болон бусад орнуудад экспортлох чухал нөхцөл боллоо.

Эдгээр нааштай үр дүнг урт хугацааны хүчин чармайлттай хослуулснаар хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт, ялангуяа бэлчээр ашиглалтын чиглэлд ШХА онцгой чухал байр суурь эзэлдэг. Энэ хугацаанд олж авсан гол сургамж бол малчид, тариаланчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай борлуулахын тулд чанарыг сайжруулж, малчдыг зах зээлтэй шууд холбох явдал гэж үзэж байна.

**Мэргэжлийн боловсрол, сургалт**

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт ШХА-ийн оруулсан хөрөнгө оруулалтаар мэргэжлийн сургуулийн удирдлага, багш нарыг мэргэшүүлэх, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, орчин үеийн багаж, тоног төхөөрөмжөөр хангах зэрэг дэмжлэг үзүүлснээр тус улсын мэргэжлийн сургалтын чанар, салбарын нэр хүндийг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулсан. Энэхүү хамтын ажиллагааны үр шимийг нийт 11 сургалтын төвийн 10,800 орчим оюутан хүртээд байна.

ШХА–аас мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг нэвтрүүлж, МБС болон хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн хүрээ, бодлогын чиглэлээр төр засгийн байгууллагуудад зөвлөгөө өгснөөр залуучуудыг боловсролоос хөдөлмөрийн зах зээлд шилжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулан ажилласан. Мөн ШХА нь МБС-ын салбарын хөгжлийн тулгуур болох төр болон хувийн хэвшлийн нягт түншлэлийн үр дүнг бодитоор харуулж чадлаа. Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөр болон ажил мэргэжлийн стандарт боловсруулах аргачлалыг хамтран боловруулж, орон нутгийн МБС-ын салбар зөвлөлүүд болон сургуулиуд дахь мэргэжлийн зөвлөлүүдийг байгуулж, МБС-ын төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны суурь болох аж ахуйн нэгжүүдэд дадлагажуулагч багш нарыг бэлтгэх, үйлдвэрлэлийн дадлагын тоо чанарыг нэмэгдүүлэх зэрэг замаар МБС-ын арга барилыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн шинэчилсэн зэрэг нь хувийн хэвшлийн шууд оролцоотойгоор хэрэгжүүлсэн ажлын үр дүн байлаа.

ШХА-ийн дэмжлэгтэйгээр МБС-ын салбарт зохицуулалтын төрийн бус тогтолцоо бий болсноор хэрэгжүүлэгч түншүүд, төр засгийн байгууллагын уялдаа холбоо сайжирч тус салбарын хамтын ажиллагааны үр дүн дээшилсний нотолгоо боллоо. Эдгээр олон талт арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүнд зорилтот сургуулиудыг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн дундаж үзүүлэлт 53-аас 66 хувь болж өссөн нь улсын хэмжээний дундаж үзүүлэлтээс 10 орчим хувь өндөр байна.

ШХА-аас ерөнхий боловсролын цөм хөтөлбөрийг Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалд нийцүүлэн

шинэчилж, улмаар салбарын Сайдын тушаалаар орон даяар ЕБС-ийн бүх сургуулиуд шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэллээ. Үүнд 27,000 багш, сургуулийн удирдах ажилтныг сургалтанд хамруулж, таван хичээлийн сурах бичгийг шинэчлэн засварлажээ. Түүнчлэн амьдрах ухааны хичээлийг дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулахад ШХА дэмжлэг үзүүлсэн.

Өнгөрсөн хугацаанд энэ чиглэлээр олж авсан гол сургамж нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн уялдаа холбоог сайжруулахын тулд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх нь нэн чухал гэж үзэж байна.

**Засаглалын шинэтгэл, орон нутгийн засаглал ба иргэний оролцоо**

ШХА Монгол Улсын орон нутгийн засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлснээр орон нутагт төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, нутгийн захиргааны байгууллагуудын эрх зүйн орчныг сайжруулахад хувь нэмрээ оруулллаа. ШХА орон нутгийн засаглалын чиглэлээр ажилладаг тэргүүлэх хандивлагчдын нэг болоод байна.

Мөн орон нутагт төрийн бүх үйлчилгээг нэг дороос үзүүлдэг Нэг цонхны үйлчилгээний (НЦҮ) төв 45-ыг байгуулахад дэмжлэг үзүүлэв. Ийнхүү төрийн чанартай үйлчилгээг иргэдэд ойртуулснаар төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлж, иргэдийн цаг завыг хэмнэж байна. Энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэх механизм, бүтэц, төрийн байгууллагын дэмжлэг оролцоо бий болсноор нутгийн захиргааны байгууллагууд өөрийн санхүүжилтээр 150 гаруй НЦҮ төвийг нэмж байгуулаад байна.

Орон нутгийн сонгуулийн дараа явуулсан хоёр удаагийн сургалтад орон нутгийн иргэдийн хурлын 8,000 гаруй төлөөлөгчийг хамруулж, нутгийн өөрөө удирдах байгууллагуудын чадавхыг бэхжүүллээ. Ингэснээр орон нутгийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн гүйцэтгэх засаглалд хяналт тавих, шийдвэр гаргах чадавх нэмэгдэв. Мөн орон нутгийн иргэдийн хурал дахь хүйсийн тэгш төлөөллийг хангах, хөхиүлэн дэмжих зорилгоор эмэгтэй төлөөлөгчдийн манлайлах ур чадварыг бэхжүүлэв.

Засаглалын төслийн хүрээнд хийгдэж буй олон нийтийн хэлэлцүүлэг, иргэний боловсролын компанит ажил, жижиг тэтгэлэгт хөтөлбөрийн чанарыг дээшлүүлсний үр дүнд орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)-ууд орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад оролцох явдал түгээмэл болов. Зорилтот бүс нутгийн аймаг, сум, багийн түвшинд ардчилсан оролцоот үйл явцыг дэмжиж хэрэгжүүлсний дотор малчид, эмэгтэйчүүд, үндэсний цөөнх гэх мэт эмзэг бүлгийн төлөөллийг татан оролцууллаа. Техникийн туслалцаа үзүүлэх, сургалтад хамруулах зэргээр орон нутгийн ИНБ-ын чадавх бэхжүүлснээр тэдний орон нутгийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулахад туслах, улмаар хариуцлага тооцох чадавх нь сайжирлаа.

2013 онд Төсвийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр Засгийн газар Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гаар дамжуулан орон нутагт өөрөө захиран зарцуулах санхүүжилт олгож эхэлсэн. Энэ нь төвлөрлийг сааруулах чиглэлд хийгдсэн нэг томоохон алхам байв. ШХА-ийн үзүүлсэн дэмжлэгийн үр дүнд зорилтот бүс дэх нутгийн захиргааны байгууллагууд ОНХС-ийн бүхий л мөчлөгийг төсвийн болон худалдан авалтын хууль тогтоомжид нийцүүлэн удирдах чадвартай болоод байна. Түүнчлэн 2016 онд ШХА-ийн дэмжлэгтэйгээр боловсруулж, батлагдсан Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого зэрэг үндэсний бодлого, эрх зүйн баримт бичгүүдэд холбогдох зохицуулалтыг тусгаснаар төвлөрлийг сааруулах үндэс суурийг бүрдүүлж байна.

Энэ хугацаанд олж авсан гол сургамж бол дан ганц бодлогын дэмжлэг хангалтгүй, хэрэгжүүлэлтийн дэмжлэг давхар үзүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Мөн тогтвортой байдлыг хангах талаар анхнаас нь, тухайлбал төсөл хэрэгжүүлэх чадвартай түнш байгууллагыг сонгох шатанд анхаарах шаардлагатай гэж үзлээ.

**Тогтвортой бичил уурхай төсөл**

Өнгөрсөн арав гаруй жилд хөдөөгийн 60,000-80,000 иргэдийн амьжиргааны чухал эх үүсвэр болох бичил уурхайн салбарт хүрч ажилласан гол хандивлагч нь ШХА байлаа. ШХА Тогтвортой бичил уурхай төслөөрөө (ТБУТ) дамжуулан Монголд бичил уурхайн үйл ажиллагааг зохион байгуулах, албажуулахад дэмжлэг үзүүлсэн. Өнөөдөр бичил уурхайн асуудлыг Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2015), Ашигт малтмалын тухай хууль (2014), Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр 2016 - 2020 (2016), Алт II (2017) хөтөлбөрт тус тус тусгаад байна. ШХА-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам нь (2016 оны байдлаар 1,800 орчим га талбайг бичил уурхайн зориулалтаар олгоод байна) газар олголт, төрийн байгууллагуудын уялдаа холбоог зохицуулах, бичил уурхайн газрын нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй зэрэг асуудлуудыг шийдвэрлэсэн байна.

Бичил уурхайг албажуулснаар бичил уурхайчдын дундаж орлого 2014 - 2015 онд 55 хувиар, 2016 онд нэмж 12 хувиар өссөн байна. 2016 онд Монголбанкинд тушаасан нийт алтны 50 гаруй хувь нь иргэдээс тушаагдсан бөгөөд үүнд бичил уурхайгаар олборлосон алт багтаж буй юм. Төслөөс Шударга олборлолтын стандартаар гэрчилгээжүүлэх ажиллагааг хөхиүлэн дэмжиж, бичил уурхайн ТББ-ыг дэмжсэний үр дүнд 2016 онд анхны ТББ нэг килограмм алтаа зохих ёсоор баталгаажуулж экспортод гаргасан нь Азидаа анхдагч жишээ боллоо.

ТБУТ бичил уурхайд мөнгөн ус ашиглахыг багасгах тухай Минаматагийн конвенцид хувь нэмрээ оруулж байна. Мөн ШХА бичил уурхайн байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах үүднээс нөхөн сэргээлтийн аргачлалыг нэвтрүүллээ. Аргачлалыг боловсруулах ажлын хүрээнд бичил уурхайн 200 гаруй га орхигдсон талбайд орон нутгийн хамтарсан санхүүжилттэйгээр нөхөн сэргээлт хийллээ.

Төслөөс Бичил уурхайн Мэдлэгийн төвийг байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам цаашид үргэлжлүүлэн ажиллуулахаар төлөвлөж байна. Мэдлэгийн төв нь бичил уурхайн салбарын үндэсний болон олон улсын түвшинд бий болсон үр дүнг институтжүүлэх, түгээн дэлгэрүүлэх нэг чухал хэрэгсэл юм.

Цаашдаа Монголын бичил уурхайн салбарт нэмүү өртгийн үр дүнтэй сүлжээ бий болгох, татварын тогтолцоог шинэчлэх, бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээг албажуулах, шинэ журмыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх зэрэг асуудлууд тулгамдаж байна. ТБУ төсөл 2019 онд дуусахтай холбогдуулан ирэх хоёр жилийн хугацаанд ШХА хүрсэн ололт амжилтуудаа нэгтгэн бататгаж, хамтрагч талуудад хүлээлгэж өгөх юм.



# 4. Үйл ажиллагааны чиглэлд орж буй өөрчлөлт

Хувьсан өөрчлөгдөж буй хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал, ШХА-ийн өнөөг хүртэл хүрсэн үр дүнг харгалзан Хамтын ажиллагааны шинэ стратегид дараах зохих өөрчлөлтүүдийг тусгалаа.

**Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр** ШХА ирэх дөрвөн жилд бэлчээрийн тогтвортой менежмент, малын эрүүл мэндийн төсөл, хүнсний ногоо үйлдвэрлэлийн төслүүдийнхээ хамрах хүрээг тэлж, үр дүнг бататган, улмаар дуусгавар болгоно. Төслүүдийн үр дүнгийн тогтвортой байдлыг хангахын тулд зах зээлийн чиг баримжаа, нэмүү өртгийн сүлжээний аргыг бататгаж, орон нутгийн түншүүдийнхээ чадавхыг бэхжүүлнэ. 2021 оноос цааш энэ чиглэлээр гол төлөв хөдөө орон нутагт тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй асуудлууд (гол төлөв бэлчээрийн доройтол, цөлжилт) руу анхаарлаа хандуулна. Мөн хот суурин газрын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг (эрчим хүчний үр ашиг, агаарын бохирдол) үндсэндээ засаглалын талаас нь, мөн эрсдлийг бууруулах, дасан зохицох зэрэг байдлаас нь илүүд авч үзнэ.

Ажилгүйдлийн түвшин харьцангуй өндөр байгаатай холбогдуулан **Суурь боловсрол, мэргэжлийн сургалтын (СБМС)** чиглэлийн хөтөлбөрийн ач холбогдол хэвээр байна. ШХА-аас мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх чиглэлээр хүрсэн үр дүнгээ нэгтгэж, тогтвортой байдлыг нь хангахын зэрэгцээ Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг ерөнхий боловсролын дунд сургуулиудад нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд анхаарна. Дэлхийн Банк, АХБ, Европын Холбоо, Германы Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны яам зэрэг нөлөө бүхий түншүүд МБС болон хөдөлмөр эрхлэлтийн салбарт үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ. Иймээс ШХА-ийн хамтын ажиллагааны нийт төсөв буурч байгаагаас шалтгаалан СБМС-ын чиглэлийн хөтөлбөрөө 2018 - 2021 оны хугацаанд хэрэгжүүлж дуусгана. Ингэснээр, ШХА нь үйл ажиллагаагаа шинэ сорилт бэрхшээлийг шийдвэрлэхэд төдийгүй Швейцарын онцлог давуу талыг харуулж, илүү хувь нэмэр оруулж болох шинэ салбар, чиглэл болон хэрэгжүүлэх арга хэлбэрийг сонгоход чиглүүлэх юм.

**Сайн засаглал** ШХА-ийн тэргүүлэх чиглэл хэвээр байна. Ил тод, иргэдэд ээлтэй, хариуцлагатай төр нь улс орны нөөц баялгийг тэгш хуваарилах гол суурь нөхцөл юм. ШХА энэ чиглэлээрх үйл ажиллагаагаа нэмэгдүүлж Швейцарын мэдлэг туршлага, харьцангуй давуу талд тулгуурлан бодлогын дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ гаргасан хууль тогтоомж, бодлогын үр дүнтэй хэрэгжилтийг хангахад туслалцаа үзүүлнэ. Иргэдийн оролцоо, нийгмийн эгэх хариуцлагын механизмуудыг бэхжүүлэх чиглэлээр ажиллана. Ус, хог хаягдлын менежмент, эрчим хүчний үр ашиг, газрын удирдлага зэрэг холбогдох салбаруудад засаглалыг сайжруулахад дэмжлэг үзүүлж төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, улмаар ядуу, эмзэг бүлгийнхэнд бодитой үр дүн өгөхүйц бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулна.

Эдийн засаг, нийгмийн олон хүчин зүйлсээс үүдэлтэй **хотжилт эрчимжиж,** хөдөөнөөс шилжин ирэгсэд гол төлөв гэр хороололд суурьшиж хүрээг нь хэт тэлж байгаа нь шийдвэрлэх томоохон асуудлын нэг болоод байна. Гэр хороололд оршин суугчдын хувьд усан хангамж, бохир усны шугам, төвлөрсөн халаалт, эрчим хүч гэх мэт суурь үйлчилгээний хүртээмж хангалтгүй, тэгш бус байдаг. Тэд мөн агаарын бохирдолд ихээр өртөхийн зэрэгцээ түүнд багагүй хувь нэмэр оруулж байдаг. ШХА энэхүү өргөжин тэлж буй хот суурин газрын болон хотын захын оршин суугчдад анхаарлаа хандуулж, ялангуяа үйлчилгээний хүртээмж, агаарын бохирдолтой холбоотой засаглалын асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж байна. Түүнчлэн хөдөө орон нутагт иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах нь хот суурин газруудад үзүүлэх шилжилт хөдөлгөөний дарамтыг бууруулах ач холбогдолтой. Цаашид дотоодын шилжилт хөдөлгөөн, эмзэг байдлын үнэлгээг хийх нь дараа дараагийн үйл ажиллагааны үндэс суурь болно. Мөн малчид, тариаланчдын зах зээлд нэвтрэх боломжийг хөхиүлэн дэмжих замаар хот, хөдөөгийн уялдаа холбоог бэхжүүлнэ.

ШХА нь **ядуурлыг бууруулах, жендерийн тэгш байдлыг хангахад** илүү анхаарна. Үүний тулд нийт иргэдийн тэгш оролцоог хангахад чиглэсэн сайн засаглал, хөдөө аж ахуйн хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллана. Хөдөө орон нутагт гол төлөв малчид, жижиг тариаланчид төслийн үр шимийг хүртэгсэд хэвээр байх бол хот суурин газрын хувьд бүртгэлгүй шилжин суурьшигсад, ганц бие өрх толгойлсон эцэг, эх (голдуу эхчүүд), ажилгүйчүүдэд голлон анхаардаг. Иймд иргэдийн тэгш оролцоог хангах, ядуурлыг бууруулах талаарх үйл ажиллагааныхаа төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулахад чиглэсэн ядуурлын судалгаануудыг хийж гүйцэтгэнэ. Монгол Улсын нөөц баялгийн байдал, ядуурлыг бууруулах чиглэлээр өнөөг хүртэл хүрсэн ололт амжилтыг харгалзан үзвэл энэхүү Хамтын ажиллагааны стратеги нь ШХА-ийн Монгол дахь хамтын ажиллагааг Дундаас дээш орлоготой орнуудад зориулсан бодлогод (дэлгэрэнгүйг 6 дугаар бүлгээс үзнэ үү) нийцүүлэн өөрчлөх үндэс суурь болох юм.

# 5. Тэргүүлэх чиглэл ба зорилтууд

2018 - 2021 оны Швейцарын Хамтын ажиллагааны стратегийн эрхэм зорилго бол иргэн бүрт хүртээмжтэй, эрх тэгш, ногоон, хөгжингүй нийгмийг байгуулах Монгол Улсын иргэд, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах явдал юм. ШХА энэ зорилгоо (1) Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал, (2) Суурь боловсрол ба мэргэжлийн сургалт, (3) Засаглал гэсэн харилцан уялдаатай гурван үндсэн чиглэлд дэмжлэг үзүүлэх замаар биелүүлнэ.

Шинээр боловсруулсан энэхүү стратеги нь өмнөх сургамж ба одоогийн туршлагаа үргэлжлүүлэн, бататган бэхжүүлэхэд чиглэнэ. Өмнөх үр дүнгээ нэгтгэн, институцжүүлэх замаар ШХА-ийн хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангана. Эдгээр гурван үндсэн чиглэл нь Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх чиглэлд төдийгүй Швейцар Улсын 2017 - 2020 оны Олон улсын хамтын ажиллагааны бодлогод нийцсэн болно.

**Үндсэн чиглэл 1: Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал**

Бэлчээрийн даац хэтрэлт, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн бэлчээрийн доройтлын асуудал хөдөөгийн хүн амын 70 хувийг бүрдүүлдэг малчин өрхүүдийн амьжиргаанд эрсдэл учруулж байна. Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, малын эрүүл мэндийг сайжруулах, малчдыг зах зээлийн боломжуудтай холбох нь малын гаралтай бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, малчид болон жижиг тариаланчдын амьжиргааг сайжруулахад зайлшгүй шаардлагатай.

Энэхүү үндсэн чиглэлийн *зорилго нь хөдөөгийн эмзэг бүлгийн малчид, хот орчмын жижиг тариаланчдын амьжиргааг тогтвортой дээшлүүлж ногоон хөгжилд хувь нэмрээ оруулах явдал* юм. Хүлээгдэж буй үр дүн нь: (1) Хөдөө аж ахуйн тогтвортой удирдлага, зохицуулалтын бодлогын цар хүрээ, тогтолцооны чадавхыг сайжруулах; (2) Хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний чанар, зах зээлийн боломжийг дээшлүүлэх замаар эмзэг бүлгийн малчид, өрхийн тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх явдал юм.

Дээрх зорилгоос үүдэх үр нөлөө нь хөдөөгийн болон хот орчмын малчид, өрхийн тариаланчид, тэдний үүсгэн байгуулсан байгууллагуудын чадавх бэхжсэн, мөн салбарын бодлого зохицуулалт, тогтолцоо нь тогтвортой, ногоон хөгжлийг дэмждэг болж сайжирсан нөхцөлд тэдгээр малчид, өрхийн тариалан эрхлэгчдийн амьжиргаа дээшилнэ



гэж үзэж байна. ШХА малчдад тулгуурласан бэлчээрийн тогтвортой менежментийн загваруудыг өргөжүүлж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ. Үүгээр нэг нутаг усны малчид бэлчээр ашиглалтын хэсгийн зохион байгуулалтанд орж, бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж ажиллахыг дэмжинэ. Эмзэг бүлгийн малчид, өрхийн тариаланчдын орлогыг нэмэгдүүлэхийн тулд гишүүдэд суурилсан малчин, тариаланчдын байгууллага, хоршоодын тогтвортой ажиллагааг хангах талаар ажиллана. Зах зээлийн боломжийг нэмэгдүүлэх, хүнсний ногооны нэр төрлийг олшруулан, шинэ сортыг нэвтрүүлэх, тухайн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах ба гарал үүслийн гэрчилгээ олгох тогтолцоог хөгжүүлэхийг дэмжинэ. Төслүүдийн хэрэгжүүлсэн сайн үр дүн, нотолгоонд тулгуурлан тогтолцоог сайжруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхэд үргэлжлүүлэн анхаарна.

Тогтвортой байдлыг хангаж, өнөөг хүртэл гаргасан үр дүнг нэгтгэн бататгах нь Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын үндсэн чиглэлийн гол зорилт учраас эдгээр үйл ажиллагаа, үр дүнг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний түншүүдэд хүлээлгэж өгөх төслийн төгсгөлийн шатны стратеги боловсруулна. Үүний зэрэгцээ бэлчээрийн доройтол, цөлжилтийн чиглэлээр ШХА-аас өмнө нь хэрэгжүүлсэн үйл ажиллагаандаа тулгуурлан хөдөөд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг хөндсөн төсөл боловсруулж, эхлүүлнэ.

**Үндсэн чиглэл 2: Суурь боловсрол ба мэргэжлийн сургалт**

Сүүлийн жилүүдэд гарсан эдийн засгийн өндөр өсөлт хөдөлмөр эрхлэлтийг дорвитой нэмэгдүүлж чадсангүй. Ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр (10 орчим хувь), нэн ялангуяа залуучуудын дунд ажилгүйдэл (17.4 хувь) их байна. Энэ салбарын гол тулгамдаж буй асуудал нь боловсролын чанар тааруу, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт тохирохгүй байгаатай холбоотой.

Энэ үндсэн чиглэлийн зорилго нь *иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн, боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоог өөрчлөхөд хувь нэмэр оруулахад оршино.* Хүлээгдэж буй үр дүн нь: (1) Чанартай боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн тогтолцоог бэхжүүлэх, (2) Залуучууд, насанд хүрэгсэд хөдөлмөр эрхлэх ур чадвар эзэмшиж, эзэмшсэн ур чадвараа хөдөлмөр эрхлэхэд илүү үр дүнтэй ашиглах, (3) Зах зээлийн баримжаатай мэргэжлийн боловсрол сургалтын тогтолцоог бий болгоход хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх явдал юм.

Үр нөлөөллийн таамаглалын хувьд, өндөр чанартай, эрэлтэд чиглэсэн боловсрол эзэмшиж хөдөлмөр эрхлэлтийн үр дүнтэй үйлчилгээнд хамрагдсан иргэдийн ажил эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх боломжууд нэмэгдэх болно гэж үзэж байна. ШХА нь боловсролын салбарт шинэтгэл хийх (түүний дотор, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх), эрэлт (хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ), нийлүүлэлтийн (өндөр ур чадвартай төгсөгчид) тэнцвэрийг хангасан хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо бий болгох чиглэлээр Монгол Улсад үзүүлэх дэмжлэг, туслалцаагаа үргэлжлүүлэн хүргэх болно. Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, дунд болон техник мэргэжлийн сургуулийн багш нар болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хариуцан гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх нь суралцагсдыг ажил, хөдөлмөр эрхлэхэд нэн шаардлагатай мэргэжлийн болон харилцааны ур чадвар эзэмших нөхцөл бололцоог бий болгох юм. Мэргэжлийн боловсролын сургалтын бүх шат болон бүхий л үйл явцад хувийн хэвшлийг татан оролцуулах нь бидний тэргүүлэх чиглэл хэвээр байх болно.

Энэ чиглэлийн үйл ажиллагаа 2021 онд дуусгавар болох учраас үлдэж буй дөрвөн жилд ШХА-ийн үйл ажиллагааны үр дүн, туршлагыг бататган дэлгэрүүлэхэд голлон анхаарна. Түүнчлэн, тогтвортой байдлыг хангахын тулд энэ салбарт төсөл хамтран хэрэгжүүлэх, хамтран санхүүжүүлэх боломжийг эрэлхийлэх замаар Засгийн газрын түнш байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхийг зорино.

**Үндсэн чиглэл 3: Засаглал**

Улс орны нөөц баялаг, хүлээгдэж буй эдийн засгийн сэргэлтийн үр шимийг нийт иргэд эрх тэгш, тогтвортой хүртэх боломж олгох үүднээс сайн засаглалын асуудал тус улсын хамгийн том сорилтын нэг хэвээр байна.

Энэхүү үндсэн чиглэлийн зорилго бол *иргэдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн хариуцлагатай, засгийн газар, нутгийн удирдлага болон иргэний нийгмийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах явдал юм.* Хүлээгдэж буй үр дүн нь: (1) Төвлөрлийг сааруулах чиглэлээр: Нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаа, хариуцлагатай байдлыг сайжруулах, (2) Ардчиллын чиглэлээр: Шийдвэр гаргах үйл явцад оролцох иргэдийн оролцоог дээшлүүлж, ИНБ-уудын чадавх, нийгмийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх явдал юм.

Үр нөлөөний хувьд Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын ардчилал, төвлөрлийг сааруулах шинэтгэлийн чиглэлээр чадавхыг бэхжүүлэх, бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, тэгш оролцоотой, тогтвортой хөгжлийг бий болгоход хувь нэмрээ оруулах болно гэж үзэж байна. ШХА хөдөө, хот суурин газрын гэр хорооллууд болон эмзэг бүлгийнхэнд төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор тодорхой салбарын хүрээнд (эрчим хүчний үр ашигтай байдал, газар зохион байгуулалт, хог хаягдлын менежмент гэх мэт) дэмжлэг үзүүлж ажиллах замаар Монгол Улсын Засгийн газрын төвлөрлийг сааруулах шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үргэлжлүүлэн дэмжинэ. Мөн иргэдийн оролцоог дэмжих, нийгмийн эгэх хариуцлагын механизмуудыг хэрэгжүүлэх таатай орчин бүрдүүлснээр иргэдэд ээлтэй, хариуцлагатай шийдвэр гаргах үндсийг бэхжүүлнэ. Нэг талаас нутгийн өөрөө удирдах байгууллагууд, төрийн захиргааны байгууллагууд (нийлүүлэлтийн тал), нөгөө талаас иргэд, ИНБ-уудын (эрэлтийн тал) чадавхыг бэхжүүлэх замаар Монголын ардчилсан институцүүдийн зохистой үйл ажиллагааг хангахад хувь нэмрээ оруулна.

Мөн үйл ажиллагаанысхаа үр дүнг илүү сайжруулж, тогтвортой байдлыг дээшлүүлэх үүднээс түнш байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр, техникийн туслалцаа үзүүлэх, Швейцарын мэдлэг туршлагаас хуваалцах зэргээр бодлогын дэмжлэг үзүүлэх, үндэсний болон орон нутгийн түвшинд бодлогын үр дүнтэй яриа хэлэлцээр өрнүүлэхийг дэмжиж ажиллана. Уур амьсгалын өөрчлөлт, дотоодын шилжилт хөдөлгөөний асуудал, ялангуяа тэдгээрийн хотын гэр хорооллуудад үзүүлэх нөлөө Засаглалын чиглэлээр цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны анхаарлад байх юм.

**Нийтлэг сэдвүүд: Жендэр ба засаглал**

Жендэр ба засаглал нь уг гурван үндсэн чиглэлийн бүгдэд нь хамаарах нийтлэг асуудал юм. Мөн энэ хоёр асуудал хоёулаа ерөнхий хяналт шинжилгээ, тайлангийн системийн салшгүй хэсэг байна.

Жендэрийн тэгш байдал, тэгш эрх, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдал, тоо баримтын хүйсийн ялгавартай дүн шинжилгээ гэх мэт үндсэн шаардлага бүх төслүүдэд тавигдана. Эд хөрөнгө, мэдлэг эзэмших тэгш эрх, төсөв болон шийдвэр гаргах үйл явцад адил тэгш төлөөлөл оролцох нөхцлийг хангахыг дэмжиж ажиллана. Түүнчлэн Монголд тулгамдсан нэг асуудал болох жендэрт суурилсан, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төслийг 2016 онд Засаглалын үндсэн чиглэлийн хүрээнд эхлүүлээд байна.

Засаглал өөрөө үндсэн гурван чиглэлийн нэг боловч бүх салбарыг хамарсан нийтлэг сэдэв байх болно. Үндсэн чиглэл бүрт тухайн салбарын институцийн тогтолцоог сайжруулахад чиглэсэн үр дүнг тодорхойлсон болно. Ил тод, хариуцлагатай, үр ашигтай байдал, оролцооны зарчмуудыг ШХА-ийн бүхий л үйл ажиллагаанд баримтална.

# 6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх менежмент

**Хэрэгжүүлэх арга хэлбэр**

Төсөл хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах, институцийг бэхжүүлэх, үр дүнг нэгтгэн бататгах явдлыг энэхүү стратегийн хэрэгжилтийн гол удирдлага болгоно. Үйл ажиллагаагаа Үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй нягт уялдуулж, одоогийн бий болсон тогтолцооны хүрээнд ажиллахыг эрмэлзэнэ. Ингэснээр хамтрагч талууд хөтөлбөрийг өөрсдөө хариуцан хэрэгжүүлж, цаашид тогтвортой үргэлжлүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Төр засаг, иргэний нийгмийн түнш байгууллагуудын чадавхыг бэхжүүлж тэдэнд илүү үүрэг хариуцлагыг шилжүүлэхийг зорино. Швейцарын хөгжлийн агентлаг өөрийн хэрэгжүүлж буй бүх төслийг энэхүү Хамтын ажиллагааны стратегийн төгсгөлд аажмаар дуусган хаах чиглэл баримтална. Швейцарын бусад хөтөлбөрийг аль болох бусад хандивлагчийн үйл ажиллагаатай уялдуулахад анхаарна. Үйл ажиллагааны үндсэн чиглэл тус бүрийн хүрээнд болон үндсэн чиглэл хоорондын үйл ажиллагааг харилцан уялдуулах зорилгоор тогтмол уулзалт зохион байгуулна.

ШХА-ын хамтын ажиллагаа нь Монгол Улсын хувьд хэрэгцээ шаардлага бүхий салбарт Швейцарын техникийн туслалцаа үзүүлэх, мэдлэгийг түгээхэд чиглэнэ. Ингэхдээ төр засгийн байгууллагуудаас хамтран санхүүжүүлэх явдлыг нэмэгдүүлэхийг зорьж ажиллана. Төслүүдийн үр дүн, сайн туршлага, бодлогын гол чиглэлд үндэслэн бодлогын яриа хэлэлцээрийг эрчимтэй өрнүүлнэ. Мөн ШХА-аас хувийн хэвшлийн байгууллагуудыг татан оролцуулах, гурван талт хамтын ажиллагааны (тухайлбал Хятад, Монгол, Швейцарын гурван талт хамтын ажиллагаа гэх мэт) төслүүдээр дамжуулж ажиллах боломжуудыг эрэлхийлнэ. Шинээр бий болж буй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх үүднээс Уур амьсгалын өөрчлөлтийн Швейцарын Дэлхий нийтийн хөтөлбөр (Хятад улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ШХА-ын хөтөлбөр), Усны асуудлаарх дэлхий нийтийн хөтөлбөр (ШХА-аас Төв Азийн орнуудад хэрэгжүүлж буй хөтөлбөр) гэх мэт ШХА-ын дэлхийн олон оронд хэрэгжүүлдэг түгээмэл хөтөлбөрүүдийн сайн туршлага, ноу-хауг авч ашиглана.

**Түншүүд**

Шинэ стратегийн хүрээнд хөтөлбөр нь Монгол, Швейцарын болон олон улсын чадварлаг түнш байгууллагуудтай үргэлжлүүлэн хамтарч ажиллана. Үүнд үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагууд, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, олон улсын санхүүгийн байгууллагууд (ОУСБ), ИНБ-ууд, хувийн хэвшлийн байгууллагууд орно. Швейцар улс бодлогын яриа хэлэлцээр, бодлого боловсруулах чиглэлээр бусад хандивлагчидтай нягт хамтран ажиллаж, хамтын байр суурийг дэмжиж ажиллахад бэлэн байна. Түүнчлэн хандивлагчдын үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлж, мэдээлэл солилцооны хэлбэрээс харилцан уялдаатай бодлого боловсруулах хэлбэрт шилжихийг тууштай дэмжсээр байна.

**Швейцарын хөгжлийн агентлагийн хөтөлбөрт орж буй өөрчлөлт**

Монгол Улсын эдийн засаг өсөх боломжтой хэдий ч олон шинэ хүндрэл бэрхшээлтэй





тулгарсан хэвээр байна. Энэхүү Хамтын ажиллагааны стратегийн хүрээнд 2021 оноос цааш тус улсын хөгжлийг дэмжих хөтөлбөрөө өөрчлөн шинэчилж, Дундаас дээш орлоготой бусад орнуудад түгээмэл тулгардаг шинэ сорилтуудыг даван туулахад дэмжлэг үзүүлэхэд үйл ажиллагааны арга хэлбэрийг өөрчлөх суурийг тавина. Энэ нөхцөлд мэдлэг түгээх, техникийн туслалцаа үзүүлэх, чадавхыг бэхжүүлэх зэрэг арга хэлбэр нь хөнгөлөлттэй санхүүгийн тусламжаас илүү ач холбогдолтой байна гэж үзэж байна. 2021 оноос хойших ШХА-ын Монгол дахь үйл ажиллагаа тухайлан сонгосон цөөн хэдэн салбарт төвлөрөх болно. Үүнд сайн засаглалын болон уур амьсгалын өөрчлөлт зэрэг дэлхий нийтийн өмнө тулгамдсан түгээмэл асуудлууд, (үүнд бэлчээрийн доройтол, агаарын бохирдол, хөдөөгөөс хотын гэр хороолол руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн гэх мэт) багтана. Хувийн хэвшил болон ШХА-ийн дэлхий нийтийн хөтөлбөрүүдтэй хамтын ажиллагааг эрчимжүүлнэ. Бусад улсад амжилттай хэрэгжсэн төслүүдийн сайн туршлагыг дэлгэрүүлж, Монголын нөхцөлд тохируулан нутагшуулах талаар ажиллахаар төлөвлөж байна. Эдгээр тодорхой чиглэлээрх мэдлэг туршлагыг Монгол дахь ШХА-ийн хуримтлуулсан мэдлэг туршлагатай хослуулан хэрэгжүүлж хамтран санхүүжүүлнэ. Өмнө дурдсанчлан, хамтын ажиллагааны олон хэлбэр, арга замыг ашиглахын зэрэгцээ үр нөлөөг сайжруулах мэдлэгийн зуучлагчийн үүргээ бататгаж ажиллана. 2020 он хүртэл шинэлэг санаа, шинэ арга хэлбэрийг турших боломж олгож буй “Хэтийн төлөв 2020” төслөөс харахад Монгол дахь ШХА-д шинэ салбар (уур амьсгалын өөрчлөлт гэх мэт), шинэ арга зам (техникийн туслалцаа гэх мэт), хамтын ажиллагааны шинэ хэлбэр (гурван талт хамтын ажиллагаа гэх мэт) зэргийг туршиж үзэх замаар энэхүү өөрчлөлтийн бэлтгэлийг хангах юм. 2019 оны намар хийгдэх Хамтын ажиллагааны стратегийн дунд хугацааны үнэлгээнээс уг шилжилтийг хэрэгжүүлэх эсвэл үйл ажиллагааг дуусгавар болгох эсэхийг нарийвчилан тодорхойлох болно.

## Санхүүжилт

Хамтын ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхэд зориулсан санхүүжилтийн дүн энэ хугацаанд нийт 51.5 сая шв.франк байх бөгөөд энэ нь ШХА-аас санхүүжүүлэх дүн юм. Төсөв 2018 онд 13.5 сая шв.франк байх бол 2021 онд 12 сая шв.франк болж буурна. 2021 оноос хойших шилжилтийн хөтөлбөрийг турших шинэ төслүүдийн санхүүжилтыг Засаглалын болон Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын үндсэн чиглэлийн төсөвт тусгасан.

**Төлөвлөсөн санхүүжилт** (сая шв.франкаар, тоймлосон тоо)

| Үндсэн чиглэл | 2018 | 2019 | 2020 | 2021 | Нийт | % |
|---|---|---|---|---|---|---|
| Засаглал | 3.9 | 6.3 | 7.7 | 7.7 | **25.6** | 50% |
| Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал | 3.9 | 2.8 | 2.2 | 2.2 | **11.1** | 22% |
| Суурь боловсрол, мэргэжлийн сургалт | 3.7 | 2.6 | 1.6 | 1.6 | **9.5** | 18% |
| Бусад төсөл | 2.0 | 1.8 | 1.0 | 0.5 | **5.3** | 10% |
| **Жилийн нийт дүн** | **13.5** | **13.5** | **12.5** | **12.0** | **51.5** | 100% |

# 7. Стратегийн удирдлага

Хамтын ажиллагааны стратегийн хэрэгжилтэд Монгол дахь Швейцарын Хамтын ажиллагааны газраас системтэй хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хяналт шинжилгээ, үнэлгээний цогц систем нь (Хавсралт 4) төсөл хөтөлбөрийн ач холбогдол, үр нөлөө, үр ашиг зэргийг дүгнэж, үр дүнгийн тайланд тусгаж баримтжуулах, хариуцлагын талаар дүгнэхийн зэрэгцээ шаардлагатай бол засаж залруулах боломжийг олгоно. Мөн энэхүү хяналт шинжилгээ, үнэлгээ нь тасралтгүй суралцах үйл явцыг дэмжинэ.

**Улс орны ерөнхий нөхцөл байдлыг** гол төлөв жил бүрийн Швейцарын хөгжлийн агентлагийн дотоод хяналтын системийн дагуу хянах бөгөөд энэ нь тухайн улсад гарч буй улс төр, нийгэм, эдийн засаг, байгаль орчны өөрчлөлтүүдийг бүртгэж, тэдгээрийн ШХА-ийн хөтөлбөрт үзүүлж болзошгүй нөлөөллийг хэлэлцдэг систем юм. Мөн ШХА болон ОУСБ-ууд, НҮБ-ын болон дотоодын байгууллагууд зэрэг бусад ажиглагчид, оролцогчдын хийсэн улс төр, эдийн засаг, хөгжлийн чиглэлийн тодорхой дүн шинжилгээг нэмж ашиглана.

**Швейцарын хөтөлбөрийн багц, тэдгээрийн үр дүнд** гол төлөв Хавсралт 2-т дурдсан Үр дүнгийн хүрээнд тулгуурлан хяналт тавина. Үр дүнгийн хүрээний үзүүлэлтэд төслийн шалгуур үзүүлэлтүүд, төр засгийн бодлогод тусгасан үндэсний хэмжээний үзүүлэлтүүд, ШХА-ийн Нэгдсэн жишиг шалгуур үзүүлэлтүүд (НЖШҮ), салбарын стандарт шалгуур үзүүлэлтүүд тус тус орно. Үзүүлэлтүүдийг тухайн сэдэвт холбогдолтой эсэх, үнэн бодитой, практикт хэрэглэх боломж, төлөөлөх чадвар, ШХА-ийн үйл ажиллагааны ололт амжилтыг хэмжих, мэдээлэх боломж зэрэгт үндэслэн сонгож авсан. Шалгуур үзүүлэлтийн тайлбарыг Хавсралт 3-т тусгав. Тоон үзүүлэлтүүдэд тулгуурласан хяналт шинжилгээнд нэмэлт болгож чанарын судалгаа, үнэлгээ, жишээ судлалыг Хамтын ажиллагааны стратегийн туршид шаардлагатай гэж үзсэн тохиолдол бүрт авч хэрэглэнэ. Түүнчлэн хөтөлбөрийн удирдлага, тайлагнал, хариуцлагын тогтолцоонд зориулсан Жилийн тайланг ашиглана. Хяналт шинжилгээний матриц нь үндсэн чиглэл бүрийн хүлээгдэж буй үр дүндээ хүрэх ахиц дэвшлийг нэг дор товч үнэлэх боломж олгоно. Мөн үндэсний төрийн байгууллагуудын тайлан, статистик тоо баримт, төслийн түншүүдийн тайлан, оролцогч талуудын хэлэлцүүлэг, төсөл хөтөлбөртэй газар дээр нь танилцах аялал зэрэг нь Швейцарын хөтөлбөрийн талаарх ажиглалтуудыг баяжуулж өгнө.

Төсөл бүрийн хувьд дунд хугацааны үнэлгээ, төгсгөлийн шатны үнэлгээ зэрэг хэрэгжилтийн үе шат бүрт тавигдах шаардлагын дагуу хөндлөнгийн үнэлгээ хийлгэхээр төлөвлөсөн байдаг. Хамтын ажиллагааны стратегийн хувьд Дунд хугацааны үнэлгээ хийхээр төлөвлөсөн бөгөөд үүнд хөтөлбөрийн 2021 оноос цааших өөрчлөлтийн асуудлыг авч үзэх ба ШХА-аас Монгол Улсад цаашид хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөр, үйл ажиллагааны талаар санал зөвлөмж гаргана. Дунд хугацааны үнэлгээг 2019 оны намар хийж, стратегийн шийдвэрүүдээ Швейцарын Олон улсын хамтын ажиллагааны дараагийн бодлогод нийцүүлж гаргана.

**Швейцарын Хамтын ажиллагааны газрын хөтөлбөрийн удирдлагад** Дотоод хяналт шинжилгээний системийн дагуу хяналт тавих бөгөөд хэрэгжилтийн тайланг жил бүр гаргана. Энэ нь ШХА-ийн дүрэм заавры мөрдөж биелүүлж буй эсэх, үйл ажиллагаандаа үр ашигтай байдлыг эрхэмлэж буй эсэх мөн үйл ажиллагаа, санхүүгийн үйл явцтай холбоотой гол анхаарах асуудлууд, эрсдэл, хүний нөөц, мэдлэгийн удирдлагад үнэлгээ хийх боломж олгоно. Түүнчлэн хөтөлбөрийн үр дүнг нэгтгэн бататгаж, 2021 оноос цааших өөрчлөлттэй холбоотой тусгай үзүүлэлтүүдийг Үр дүнгийн хүрээгээр (үзүүлэлт 6) дэлгэрэнгүй тайлбарлана.



# Хавсралт 1: Хамтын ажиллагааны стратегийн товчоон

| 2018-2021 оны Швейцарын хамтын ажиллагааны стратеги (ШХАС)-ийн товчоон | | |
|---|---|---|
| **Ерөнхий зорилго** | | |
| Иргэн бүрт хүртээмжтэй, эрх тэгш, ногоон, хөгжингүй нийгмийг байгуулах Монгол Улсын иргэд, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулна. | | |
| **Хөтөлбөрийн үндсэн чиглэлүүд** | | |
| **Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал** | **Суурь боловсрол, мэргэжлийн сургалт** | **Засаглал** |
| Нийтлэг сэдвүүд: Жендэрийн тэгш байдал ба Засаглал | | |
| **Үндсэн чиглэлийн зорилго** | | |
| *Хөдөөгийн эмзэг бүлгийн малчид, хот орчмын жижиг тариаланчдын амьжиргааг тогтвортой дээшлүүлж ногоон хөгжилд хувь нэмрээ оруулах* | *Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн, боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоог өөрчлөхөд хувь нэмрээ оруулах* | *Иргэдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн хариуцлагатай, засгийн газар, нутгийн удирдлага болон иргэний нийгмийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах* |
| **Хүлээгдэж буй үр дүн** | | |
| • Хөдөө аж ахуйн тогтвортой удирдлага, зохицуулалтын бодлогын цар хүрээ, тогтолцооны чадавхыг сайжруулах;<br>• Ажлын бүтээмж, бүтээгдхүүний чанар, зах зээлийн боломжийг дээшлүүлэх замаар эмзэг бүлгийн малчид, жижиг тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх | • Чанартай боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн тогтолцоог бэхжүүлэх,<br>• Залуучууд, насанд хүрэгчид хөдөлмөр эрхлэх ур чадвар эзэмшиж, эзэмшсэн ур чадвараа хөдөлмөр эрхлэхэд илүү үр дүнтэй ашиглах,<br>• Зах зээлийн баримжаатай мэргэжлийн боловсрол сургалтын тогтолцоог бий болгоход хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх | • Төвлөрлийг сааруулах чиглэлээр: Нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаа, хариуцлагатай байдлыг сайжруулах,<br>• Ардчиллын чиглэлээр: Шийдвэр гаргах үйл явцад оролцох иргэдийн оролцоог дээшлүүлж, ИНБ-уудын чадавх, нийгмийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх |
| **Төсөв** | | |
| 11.1 сая шв.франк | 9.5 сая шв.франк | 25.6 сая шв.франк |

# Хавсралт 2: Үндсэн чиглэлүүдийн үр дүнгийн хүрээ

<table>
<tr><td colspan="3">2018-2021 оны ШХАС-ийн зорилго: Иргэн бүрт хүртээмжтэй, эрх тэгш, ногоон, хөгжингүй нийгмийг байгуулах Монгол Улсын иргэд, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулна.</td></tr>
<tr><td colspan="3">Хөтөлбөрийн үндсэн чиглэл 1: Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал<br><br>Үр нөлөөний таамаглал:<br>Хөдөөгийн болон хот орчмын малчид, өрхийн тариаланчид, тэдний үүсгэн байгуулсан байгууллагуудын чадавх бэхжсэн, мөн салбарын бодлого зохицуулалт, тогтолцоо нь тогтвортой, ногоон хөгжлийг дэмждэг болж сайжирсан нөхцөлд тэдгээр малчид, өрхийн тариалан эрхлэгчдийн амьжиргаа дээшилнэ.</td></tr>
<tr><td colspan="3">Үндсэн чиглэлийн зорилго: Хөдөөгийн эмзэг бүлгийн малчид, хот суурин газрын жижиг тариаланчдын амьжиргааг тогтвортой дээшлүүлж ногоон хөгжилд хувь нэмрээ оруулах</td></tr>
<tr><td>(1) Швейцарын хөтөлбөрийн үр дүн</td><td>(2) Швейцарын хөтөлбөрийн хувь нэмэр</td><td>(3) Монгол Улсын хөгжлийн үр дүн</td></tr>
<tr><td>Үр дүнгийн тодорхойлолт 1:<br><br>Хөдөө аж ахуйн тогтвортой удирдлага, зохицуулалтын бодлогын цар хүрээ, тогтолцооны чадавхыг сайжруулах<br><br>Үзүүлэлт, тоо баримтын эх сурвалж:<br><br>1) Үндэсний хэмжээнд боловсруулсан холбогдох бодлого, хууль тогтоомж, стратеги, төлөвлөгөөний тоо (Эх сурвалж: Үндэсний хууль тогтоомжийн бүртгэл) (ШХА-ийн Нэгдсэн жишиг шалгуур үзүүлэлтүүд (НЖШҮ-FS2)<br><br>2) Орон нутгийн удирлагын баталсан бэлчээр ашиглалтын гэрээний тоо (Эх сурвалж: Ногоон алт, Малын эрүүл мэнд төсөл (Ногоон алт төсөл))<br><br>3) Бэлчээрийн удирдлага, Бэлчээр ашиглагчдын хэсгийн системд оруулсан төсвийн хөрөнгө оруулалтын өсөлт (Эх сурвалж: Ногоон алт төсөл)</td><td>1 ба 3-н уялдаа холбоо<br><br>ШХА-ийн хувь нэмэр:<br>• Нөлөөллийн үйл ажиллагаа, бодлогын яриа хэлэлцээрийн замаар хөдөө аж ахуйн эрх зүйн болон институцийн тогтолцоог сайжруулна.<br>• Бэлчээрийн тогтвортой удирдлагын амжилттай хэрэгжсэн загваруудыг үндэсний бодлогод тусгах, түгээн дэлгэрүүлнэ.<br>Эдгээр хувь нэмэр нь малчдын оролцоог нэмэгдүүлсэн бэлчээрийн тогтвортой удирдлагаар хангах боломж олгоно.<br><br>Эерэг хүчин зүйлс буюу төсөөлөл:<br>– Шийдвэр гаргагчид, малчдын бэлчээрийн доройтлын талаарх мэдлэг мэдээлэл дээшилнэ<br>– Хөдөө аж ахуйн салбарт тогтвортой удирдлагын зохицуулалтын тогтолцоог бий болгох улс төрийн хүсэл зориг бий болно (Бэлчээр хамгаалалт, малын эрүүл мэндийн тухай хуулиуд)<br>– БАХ/БАГ-ний арга үр дүнтэй хэвээр байж туршлагыг түгээн дэлгэрүүлнэ, Бэлчээр хамгаалалтын тухай хуульд тусгана.<br><br>Сөрөг хүчин зүйлс буюу эрсдэл:<br>– Уур амьсгалын өөрчлөлтийн (ган) нөлөөгөөр бэлчээрийн доройтол эрчимжиж байна.</td><td>Үр дүнгийн тодорхойлолт 1:<br><br>Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (ТХҮБ) 2.1.1. Зорилт 1: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.<br><br>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (ЗГҮАХ) 2.36. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, төлөв байдлыг тогтоох, хянах, сэргээн сайжруулах, доройтол, талхагдал, цөлжилтийг бууруулах, бэлчээрт хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавжтай тэмцэхэд малчдын оролцоог нэмэгдүүлж, байгаль орчинд халгүй, дэвшилтэт аргыг ашиглана<br><br>Улсын түвшний үзүүлэлтүүд:<br>1) Амины малын тоо (Эх сурвалж: УСГ)<br><br>2) Бэлчээрийн доройтлын хувь (Эх сурвалж: Ногоон алт төсөл)<br><br>3) Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь (Эх сурвалж: УСГ)</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | – Малчид, уул уурхайн салбар, газар тариалан эрхлэгчдийн газар эзэмших эрхийн хооронд ашиг сонирхлын зөрчил үүсч Бэлчээр хамгаалалтын тухай хууль батлах үйл явцыг хойш татаж байна. | |
| **Үр дүнгийн тодорхойлолт 2:**<br><br>Ажлын бүтээмж, бүтээгдхүүний чанар, зах зээлийн боломжийг дээшлүүлэх замаар эмзэг бүлгийн малчид, жижиг тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх<br><br>**Үзүүлэлт, тоо баримтын эх сурвалж:**<br><br>4) Орлого нь нэмэгдсэн (эрэгтэй/эмэгтэй) малчид, тариаланчдын тоо<br>*(Эх сурвалж: Ногоон алт төсөл, Монгол ногоо төсөл)*<br>(*ШХА-ийн Нэгдсэн жишиг шалгуур үзүүлэлтүүд - Е1*)<br><br>5) Дэмжлэг авсан хоршоодын борлуулалтын өсөлт *(Эх сурвалж: Ногоон алт төсөл, Монгол ногоо төсөл)*<br><br>6) Дотоодын зах зээл дээр байгаа хүнсний ногооны батлагдсан сортын тоо<br>*(Эх сурвалж: Улсын сорт сорилтын зөвлөлийн товч мэдээ)*<br><br>7) Эмэгтэй тэргүүнтэй Бэлчээр ашиглагчдын хэсэг, хоршооны эзлэх хувь<br>(*Эх сурвалж: Монгол ногоо төсөл, Ногоон алт төсөл*) | **1 ба 3-н уялдаа холбоо**<br><br>ШХА-ийн хувь нэмэр:<br>• Орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааны ачаар гишүүдэд түшиглэсэн малчид, тариланчдын байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлнэ;<br>• Хүнсний ногоо тариалах арга техник, зах зээлийн боломжийг сайжруулах замаар маркетинг хийнэ;<br>• Сонгож авсан бүтээгдэхүүний (сарлагийн хөөвөр, тэмээний ноос, мах) чанарыг сайжруулж гарал үүслийн гэрчилгээ олгох тогтолцоог нэвтрүүлнэ.<br>Энэ нь илүү тогтвортой, төрөлжсөн, тэгш оролцоог хангасан хөдөө аж ахуйн салбартай болох боломж олгоно.<br><br>**Эерэг хүчин зүйлс буюу төсөөлөл:**<br>– Эдийн засгийг төрөлжүүлэхэд чиглэсэн засгийн газрын идэвх зүтгэл өндөр хэвээр байна<br>– Хүнсний ногооны дотоодын хэрэгцээ үргэлжлэн өсч байна (хоол тэжээлийн тэнцвэртэй байдлын тухай ойлголт мэдлэг дээшилсэн, эрчимтэй хотжилт зэргийн улмаас)<br>– Чанар сайтай, баталгаажсан бүтээгдэхүүний олон улсын эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байна.<br><br>**Сөрөг хүчин зүйлс буюу эрсдэл:**<br>– Ган, зуд болох, эрт эсвэл оройтож хүйтэрснээс мал хорогдож, ургац алдах<br>– Олон улсын зах зээл дээрх түүхий эд материалын (ноолуур) үнэ хэлбэлзэл ихтэй байх<br>– Малын халдварт өвчин дэгдэх. | **Үр дүнгийн тодорхойлолт 2:**<br><br>Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (ТХҮБ) 2.1.1. Зорилт 4. Малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцлийг бүрдүүлнэ<br><br>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (ЗГҮАХ) 2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр, “Үйлдвэржилтийн 21:100” хөтөлбөр, “Үндэсний үйлдвэрлэл” хөтөлбөр, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг шинээр эхлүүлж, “Атрын III аян”-ыг үргэлжүүлэн хэрэгжүүлж хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийг (түүний дотор 2.41 болон 2.25) хангана.<br><br>**Улсын түвшний үзүүлэлтүүд**:<br>4) Хөдөө аж ахуйн салбарт хоршоодын эзэмшиж буй хөрөнгийн хэмжээ, гишүүдийн тоо *(Эх сурвалж: ҮСГ)*<br><br>5) Малын гаралтай бүтээгдэхүүний экспорт (түүхий ноолуур, боловсруулсан мах)<br>(*Эх сурвалж: ҮСГ*)<br><br>6) Хүнсний ногооны ургац, улсын дундаж (тонн/га)<br>*(Эх сурвалж: ҮСГ)*<br><br>7) Нэг хүнд ноогдох хүнсний ногооны хэрэглээ, улсын дундаж (кг), *(Эх сурвалж: ҮСГ)* |

| |
|---|
| **(4) Үйл ажиллагааны чиглэл (Швейцарын хөтөлбөр)** |
| **Үр дүн 1**<br>- Хөдөө аж ахуйн салбарын тогтвортой, тэгш оролцоог хангасан хөгжилд хувь нэмэр оруулахуйц эрх зүй, удирдлага зохицуулалтын тогтолцоог бий болоход дэмжлэг үзүүлэх;<br>- Үндэсний институцууд, малчид, тариаланчдын байгууллагыг бэхжүүлж тогтвортой ногоон салбар бий болгох;<br>- Бэлчээрийн тогтвортой удирдлагын чиглэлд амжилттай хэрэгжүүлж буй малчдыг бэлчээр ашиглагчдын хэсгийн зохион байгуулалтад оруулж, бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах аргыг түгээн дэлгэрүүлж институтжүүлэх<br>**Үр дүн 2**<br>- Малчид, тариаланчдын хоршоодыг бүтээгдэхүүний чанар, зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэх боломжийг бүрдүүлэх, улмаар гишүүдийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр дэмжиж, бэхжүүлэх;<br>- Хамтын үйл ажиллагаа, хоршоод, хувийн хэвшлийн үйл ажиллагааны уялдаа холбооны тэргүүн туршлагыг нэгтгэн, түгээн дэлгэрүүлэх;<br>- Бүтээмжийг нэмэгдүүлэх (шинэ сорт), чанарыг сайжруулах (гарал үүсэл) боломжтой шинэ санаачлагуудыг нэвтрүүлж, түгээн дэлгэрүүлэх;<br>- Харъяа болон түнш байгууллагуудын ажилтнуудын чадавхыг бэхжүүлж, эмэгтэйчүүдийн манлайллыг нэмэгдүүлэх;<br>- Дотоодод тарьж ургуулсан хүнсний ногооны үйлдвэрлэл, хадгалалт, маркетинг, хэрэглээг хөхиүлэн дэмжих |
| **(5) Санхүүжилт, түншлэл (Швейцарын хөтөлбөр)**<br>Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын үндсэн чиглэлд дөрвөн жилийн хугацаанд нийт 11.1 сая шв.франк төсөвлөсөн байна. Энэ нь Ногоон алт, малын эрүүл мэндийн нэгдсэн төсөл, Хүнсний ногооны тогтвортой үйлдвэрлэл, маркетингийн төсөл (Монгол ногоо төсөл) гэсэн хоёр төсөлд хуваарилагдана. Эхний төсөл нь өөрөө хэрэгжүүлэх төсөл бөгөөд 2020 оны сүүлээр хэрэгжиж дуусна. Үндсэн түнш байгууллага нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Цаг уур, орчны шинжилгээний газар, малчдын болон мэргэжлийн холбоод байна. Хүнсний ногооны төслийг хэрэгжүүлэх эрхийг Хөдөөгийн хөгжлийн төлөө Монголын фермерүүдийн холбоо ТББ-д олгосон. Уг төслийн бодлогын хэсгийн НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага хэрэгжүүлнэ. |

<table>
<tr><td colspan="3">2018-2021 оны ШХАС-ийн зорилго: Иргэн бүрт хүртээмжтэй, эрх тэгш, ногоон, хөгжингүй нийгмийг байгуулах Монгол Улсын иргэд, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулна.</td></tr>
<tr><td colspan="3">Хөтөлбөрийн үндсэн чиглэл 2: Суурь боловсрол, мэргэжлийн сургалт<br><br>Үр нөлөөний таамаглал: Өндөр чанартай, эрэлтэд чиглэсэн боловсрол эзэмшиж хөдөлмөр эрхлэлтийн үр дүнтэй үйлчилгээнд хамрагдсан иргэдийн ажил эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх боломжууд нэмэгдэх болно.</td></tr>
<tr><td colspan="3">Үндсэн чиглэлийн зорилго: Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн, боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоог өөрчлөхөд хувь нэмэр оруулах</td></tr>
<tr><td>(1) Швейцарын хөтөлбөрийн үр дүн</td><td>(2) Швейцарын хөтөлбөрийн хувь нэмэр</td><td>(3) Монголын хөгжлийн үр дүн</td></tr>
<tr><td>Үр дүнгийн тодорхойлолт 1:<br><br>Чанартай боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн тогтолцоог бэхжүүлэх<br><br>Үзүүлэлт, тоо баримтын эх сурвалж:<br><br>8. ШХА-ын төслүүдийн бодитой хувь нэмэр орсон бодлогын баримт бичиг, зохицуулалтын тоо<br>(Эх сурвалж: Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл (ТХБ), Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх төсөл (МУЧХТ), Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (ЗХЭДТ))<br><br>9. ТХБ болон техник, мэргэжлийн боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан (эрэгтэй, эмэгтэй) багш, сургагч багш нарын тоо (Эх сурвалж: ТХБ төсөл, МУЧХТ) (ШХА-ийн НЖШҮ -EV2)<br><br>10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, тэдний эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх талаарх үйлчлүүлэгчдийн (эрэгтэй, эмэгтэй) сэтгэл ханамжийн байдал (Эх сурвалж: (ЗХЭДТ), ХНХЯ)</td><td>1 ба 3-н уялдаа холбоо<br><br>ШХА-ийн хувь нэмэр:<br>• Боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн шинэтгэлийн бодлого боловсруулна.<br>• Дунд болон мэргэжлийн боловсролын сургуулийн багш, сургагч нар, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнуудын чадавхыг бэхжүүлнэ.<br>Энэ нь Засгийн газарт боловсролын чанар стандартыг дээшлүүлж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилтод хүрэхэд дэмжлэг үзүүлнэ.<br><br>Эерэг хүчин зүйлс буюу төсөөлөл:<br>- Чанартай боловсрол, ажлын байр бий болгох явдал Засгийн газрын тэргүүлэх чиглэл хэвээр байна.<br>- Засгийн газраас ТХЗ-уудыг хэрэгжүүлэх, боловсролын агуулгад тогтвортой хөгжлийн чиг баримжаа суулгах үүрэг албан ёсоор авсан.<br>Сөрөг хүчин зүйлс буюу эрсдэл:<br>- Төрийн байгууллагын халаа сэлгээ их байх<br>- Төсвийн алдагдлын нөлөөгөөр нийгмийн салбарын төсвийн зарцуулалт буурах</td><td>Үр дүнгийн тодорхойлолт 1:<br><br>ТХҮБ 2.2.3. Зорилт 2: Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна.<br>ЗГҮАХ 3.3. Хүн амын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгаалал, халамжийг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө (түүний дотор 3.3.5 болон 3.3.8)<br><br>Улсын түвшний үзүүлэлтүүд:<br><br>8. Тогтвортой хөгжил, ерөнхий ба мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн салбарын талаарх шинэ ба шинэчилсэн бодлогын тоо<br>(Эх сурвалж: БСШУСЯ, ХНХЯ)<br>9. Ерөнхий болон мэргэжлийн боловсролын сургуулиудын орон тооны (эрэгтэй, эмэгтэй) багш нарын тоо<br>(Эх сурвалж: ҮСГ)<br><br>10. Ажилд зуучилсан иргэдийн тоо (Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар)</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| **Үр дүнгийн тодорхойлолт 2:**<br><br>Залуучууд, насанд хүрэгчид хөдөлмөр эрхлэх ур чадвар эзэмшиж, эзэмшсэн ур чадвараа хөдөлмөр эрхлэхэд илүү үр дүнтэй ашиглах<br><br>**Үзүүлэлт, тоо баримтын эх сурвалж:**<br><br>11. Мэргэжлийн ур чадвар олгох сургалт болон ТХБ-ыг хэрэгжүүлсэн сургуульд хамрагдсан (эрэгтэй, эмэгтэй) хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн тоо<br>*(Эх сурвалж: МУЧХТ/ТХБ)*<br>*(ШХА-ийн НЖШҮ -EV3)*<br><br>12. Ажил эрхлэлтийн боломжоо нэмэгдүүлсэн (эрэгтэй, эмэгтэй) залуучууд, насанд хүрэгчдийн эзлэх хувь<br>*(Эх сурвалж: МУЧХТ)* | **1 ба 3-н уялдаа холбоо**<br>ШХА-ийн хувь нэмэр:<br>• Сургалтын хөтөлбөр, сургалтын материал, тоног төхөөрөмжийг шинэчлэнэ.<br>• Боловсролын тогтолцоо нь ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн байдлыг сайжруулна.<br><br>Улмаар тус улсын ажилгүйдлийн түвшинг бууруулахад тусална.<br><br>**Эерэг хүчин зүйлс буюу төсөөлөл:**<br>– Техник мэргэжлийн боловсролын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг сайжрах<br><br>**Сөрөг хүчин зүйлс буюу эрсдэл:**<br>– Боловсролын “цөм хөтөлбөрийн загвар”-аас “Кэмбриджийн загвар”-т шилжих<br>– Эдийн засаг хүндэрснээр боловсролын салбарт (түүний дотор ТМБС-д) зарцуулах төсвийн санхүүжилт буурах, шинээр ажлын байр бий болгох (хувиараа хөдөлмөр эрхлэх) үйл явц удаашрах | **Үр дүнгийн тодорхойлолт 2**<br><br>ТХҮБ 2.2.1. Зорилт 2:<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна<br><br>ТХҮБ 2.2.3. Зорилт 3:<br><br>Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлнэ<br><br>**Улсын түвшний үзүүлэлтүүд**:<br><br>11. Тухайн хичээлийн жилд МБС-д хамрагдсан (эрэгтэй, эмэгтэй) оюутны тоо<br>*(Эх сурвалж: ҮСГ)*<br><br>12. Ажилгүйдлийн түвшин (эрэгтэй, эмэгтэй)<br>*(Эх сурвалж: ҮСГ)* |
| **Үр дүнгийн тодорхойлолт 3:**<br><br>Зах зээлийн баримжаатай мэргэжлийн боловсрол сургалтын тогтолцоог бий болгоход хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх<br><br>**Үзүүлэлт, тоо баримтын эх сурвалж:**<br><br>13. Хувийн хэвшил ба сургуулиудын (ерөнхий ба техник мэргэжлийн) хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний тоо<br>*(Эх сурвалж: МУЧХТ, ТХБ төсөл)*<br><br>14. Төгсөгчдийн (эрэгтэй, эмэгтэй) мэдлэг боловсрол, ур чадварын талаарх ажил олгогчдын сэтгэл ханамж<br>*(Эх сурвалж: МУЧХТ)* | **1 ба 3-н уялдаа холбоо**<br><br>ШХА-ийн хувь нэмэр:<br>• Сургууль, ажил олгогчдын хооронд үр дүнтэй хамтран ажиллана.<br>• Сурсан зүйлсээ үйлдвэрлэлийн дадлагатай илүү сайн холбоно.<br>• Техник мэргэжлийн боловсролд хувийн хэвшлийг өргөнөөр татан оролцуулна.<br><br>Энэ нь мэргэжилтэй ажилчид авах хувийн хэвшлийн эрэлт хэрэгцээг сургуулиуд илүү сайн хангаж, эргээд төгсөгчдийн ажил эрхлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.<br><br>**Эерэг хүчин зүйлс буюу төсөөлөл:** | ЗГҮАХ 3.3.9. Мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.<br><br>ЗГҮАХ 3.4.8. Шинээр сургууль төгссөн залуучуудыг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.<br><br>ЗГҮАХ 3.4.10. Гарааны бизнес эрхэлж буй залуучуудад дэмжлэг үзүүлнэ. (…)<br><br>**Улсын түвшний үзүүлэлтүүд**:<br><br>13. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн жилийн нийт санхүүжилт (төгрөгөөр)<br>*(Эх сурвалж: ХНХЯ)*<br><br>14. Залуучуудын ажилгүйдлийн түвшин (эрэгтэй, эмэгтэй)<br>*(Эх сурвалж: ОУХБ)* |

| | | |
|---|---|---|
| | − Засгийн газар сонгосон салбаруудад эдийн засгийн хөшүүрэг (татвараас чөлөөлөх гэх мэт) хэрэглэх замаар эдийн засгийн төрөлжилтийг дэмжих.<br>**Сөрөг хүчин зүйлс буюу эрсдэл:**<br>− Эдийн засгийн өсөлт буурсны улмаас дотоодын мэргэжилтэй боловсон хүчний эрэлт хэрэгцээ тогтворгүй байх. | |

**(4) Үйл ажиллагааны чиглэл (Швейцарын хөтөлбөр)**

Үр дүн 1:
- Боловсролын болон хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах, дунд сургуулийн хичээлийн хөтөлбөр, сурах бичиг, багш нарын сургалтад ТХБ-ын үзэл санааг суулгах чиглэлээр бодлогын зөвлөгөө өгөх
- Холбогдох яамдын (БСШУСЯ, БОАЖЯ, ХНХЯ) болон холбогдох төрийн байгууллагуудын (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Багш хөгжлийн хүрээлэн, Боловсролын судалгааны хүрээлэн, Монгол Улсын Боловсролын их сургууль гэх мэт) институцийн чадавхыг бэхжүүлэх

Үр дүн 2:
- Зорилтот МБС-ийн байгууллагуудын хичээлийн хөтөлбөр, сургалтын орчин, хөтөлбөрүүдийг шинэчилж, багшлах ур чадварыг чадамжид суурилсан хөтөлбөрийн олон улсын стандартад хүргэж сайжруулах
- Орон нутгийн захиргаа, ард иргэд, хувийн хэвшил, мэргэжлийн боловсролын сургуулиуд зэрэг гол оролцогч талуудтай нягт хамтран ажилласнаар сургуулийн орчинд ТХБ-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Үр дүн 3:
- Сургалтын хөтөлбөр боловсруулах, сургуулиудын шалгалт, ур чадварын үнэлгээ, мэргэжлийн зөвлөлүүдэд татан оролцуулах зэргээр боловсрол дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийг хөхиүлэн дэмжих
- Үйлдвэрлэлийн дадлагажуулагч багш нарын тогтолцоог нэвтрүүлснээр дадлагын сургалтын чанарыг сайжруулах
- Ажил мэргэжлийн баримжаа олгох, зөвлөгөө өгөх тогтолцоог улам бүр хөгжүүлж хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн чанарын зөрүүтэй байдлыг арилгах
- ЕБС, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжиж, МБС-ын дадлагын ажлыг сайжруулах, олон нийтийг хамарсан хөгжлийн ажлууд хийх.

**(5) Санхүүжилт, түншлэл (Швейцарын хөтөлбөр)**

СБМС-ын үндсэн чиглэлийн төсөв ирэх дөрвөн жилийн хугацаанд 9 сая шв.франк байна. Энэхүү стратегийн төгсгөлд СМБС-ын үндсэн чиглэл дуусгавар болно. Уг үндсэн чиглэл нь төслийн хэрэгжилтийг гэрээлэх, хамтран санхүүжүүлэх зэрэг олон хэлбэрээр хэрэгжинэ. МУЧХТ-ийг олон талт түншүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлж байна. Үүнд, ГОУХАН, ШХУ, ХБНГУ, Австралийн Засгийн газрын болон хувийн хэвшлийн төлөөлөл орно. Дараах төслийн хэрэгжүүлэх эрхийг олон улсын тендерийн аргаар сонгон шалгаруулсан байгууллагуудад олгоно. Үүнд:

- Мэргэжлийн боловсролын төслийн 2-р үе шат буюу Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийг GFA зөвлөх групп,
- ТХБ-ын төслийн 2-р үе шатыг ГОУХАН, Уппсала их сургууль, IZB Цуг их сургуулийн хамтарсан консорциумд олгосон.

Түүнчлэн төсөл хэрэгжүүлэгчид хувийн хэвшил, дотоодын ТББ-ууд, төрөлжсөн байгууллагуудтай туслан гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж, улмаар дотоодын оролцогч нарын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулна.

<table>
<tr><td colspan="3">2018-2021 оны ШХАС-ийн зорилго: Иргэн бүрт хүртээмжтэй, эрх тэгш, ногоон, хөгжингүй нийгмийг байгуулах Монгол Улсын иргэд, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулна.</td></tr>
<tr><td colspan="3">Хөтөлбөрийн үндсэн чиглэл 3: Засаглал<br><br>Үр нөлөөний таамаглал: Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын ардчилал, төвлөрлийг сааруулах шинэтгэлийн чиглэлээр чадавхыг бэхжүүлэх, бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, тэгш оролцоотой, тогтвортой хөгжлийг бий болгоход хувь нэмрээ оруулах болно.</td></tr>
<tr><td colspan="3">Үндсэн чиглэлийн зорилго: Иргэдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн хариуцлагатай, засгийн газар, нутгийн удирдлага болон иргэний нийгмийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах</td></tr>
<tr><td>(1) Швейцарын хөтөлбөрийн үр дүн</td><td>(2) Швейцарын хөтөлбөрийн хувь нэмэр</td><td>(3) Монголын хөгжлийн үр дүн</td></tr>
<tr>
<td>Үр дүнгийн тодорхойлолт 1:<br><br>Төвлөрлийг сааруулах чиглэлээр: Нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагаа, хариуцлагатай байдлыг сайжруулах<br><br>Үзүүлэлт, тоо баримтын эх сурвалж<br><br>15. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ (Эх сурвалж: Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх төсөл (ТББТ)<br><br>16. Сумдын төр, захиргааны байгууллагуудын жилийн ажлын гүйцэтгэл (Эх сурвалж: СЯ, Тогтвортой амьжиргаа 3 төслийн Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ (ЖГҮ))<br><br>17. Жендэр - УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл (Эх сурвалж: Бүх шатны сонгуулийн үр дүн) (ШХА-ийн НЖШҮ -G3)<br><br>18. Бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл (тусламж авсан хохирогчдын тоо) (Эх сурвалж: ЖСХТТ (ШХА-ийн НЖШҮ -G1)</td>
<td>1 ба 3-н уялдаа холбоо<br><br>ШХА-ийн хувь нэмэр:<br>• Засгийн газрын төвлөрлийг сааруулах бодлогын шинэтгэлийг дэмжинэ.<br>• Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны эрх бүхий байгууллагууд, сонгогдсон төлөөлөгчид болон төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлнэ.<br>• Улс төрийн шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.<br>• Нутгийн удирдлагын байгууллагуудыг жендэрийн мэдрэмжтэй болгоно.<br><br>Эдгээр хувь нэмэр нь үндэсний болон орон нутгийн бүх түвшинд засаглалыг ил тод, үр ашигтай, хариуцлагатай болгох, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зорилтыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.<br><br>Эерэг хүчин зүйлс буюу төсөөлөл:<br>- Хууль эрх зүй, зохицуулалтын бодлогын дэмжлэг (Шилэн дансны хууль гэх мэт)<br>- Улс төрийн тогтвортой байдал: ирэх дөрвөн жилд төрийн алба тогтвортой байх<br>- Төр засгаас төвлөрлийг сааруулах шинэтгэлийг тууштай дэмжсэн хэвээр байна.<br><br>Сөрөг хүчин зүйлс буюу эрсдэл:<br>- Эдийн засгийн хямрал, төсвийн хомсдлын улмаас Засгийн газрын хамтран</td>
<td>Үр дүнгийн тодорхойлолт 1:<br><br>ТХҮБ 2.4 – Зорилт 2: Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, олон нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.<br><br>ЗГҮАХ 5.1.7. Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.<br><br>Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр 2017-2021 – Зорилт 2.2.5: Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.<br><br>Улсын түвшний үзүүлэлтүүд:<br><br>15. Орон нутгийн төсвийн зарцуулалт (Эх сурвалж: УСГ)<br><br>16. Засгийн газрын үргүй зардал (Эх сурвалж: Дэлхий нийтийн өрсөлдөх чадварын тайлан)<br><br>17. Засгийн газрын үр нөлөөтэй байдал (Эх сурвалж: ДБГ)<br><br>18. Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах байр (Эх сурвалж: ХНХЯ)</td>
</tr>
</table>

<table>
<tr><td></td><td>санхүүжүүлт зогсох<br>- ОНХС-ийн санхүүжилт цаашид багасах, дунд хугацаанд нэмэгдэхгүй байх<br>- Улс төрийн тогтолцоонд “элит” бүлэг ноёрхож, авлига хээл хахууль нэмэгдэх эрсдэл</td><td></td></tr>
<tr><td>Үр дүнгийн тодорхойлолт 2:<br><br>Ардчиллын чиглэлээр:<br>Шийдвэр гаргах үйл явцад оролцох иргэдийн оролцоог дээшлүүлж, ИНБ-уудын чадавх, нийгмийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх<br><br>Үзүүлэлт, тоо баримтын эх сурвалж:<br>19. Сум, дүүргийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд баг, хорооны тэргүүлэх чиглэлийг тусгасан байдал<br>(Эх сурвалж: СЯ-ны ЖГҮ 10)<br>(ШХА НЖШҮ -GO1-тэй уялдсан)<br><br>20. Идэвхтэй үйл ажиллагаатай ИНБ-ын дотор нийгмийн эгэх хариуцлагын төсөл хэрэгжүүлэх чадвартай нь нотлогдсон ИНБ-ын эзлэх хувь<br>(Эх сурвалж: МУНЭХБТөсөл)</td><td>1 ба 3-н уялдаа холбоо<br><br>ШХА-ийн хувь нэмэр:<br>• Иргэд, ИНБ-уудын оролцоог нэмэгдүүлэхэд зориулсан зохицуулалтын таатай орчин бүрдүүлнэ.<br>• Иргэд, ИНБ-уудыг нийгмийн хариуцлагад хувь нэмэр оруулах чадварыг бэхжүүлнэ.<br>Эдгээрийн үр дүнд иргэдийн оролцоо илүү үр дүнтэй болно.<br><br>Эерэг хүчин зүйлс буюу төсөөлөл:<br>- Иргэдийн оролцоог дэмжсэн улс төрийн хүсэл зорилго хэвээр байгаа;<br>- Ард иргэдийн сэтгэл ханамжгүй байдлаас үүдэн иргэд, ИНБ-ууд шийдвэр гаргах үйл явцад оролцох сонирхол нэмэгдсэн.<br><br>Сөрөг хүчин зүйлс буюу эрсдэл:<br>- Нийгэм, эдийн засгийн байдлаас үүдсэн нийгмийн бүлгүүдийн тэгш бус оролцоо<br>- ОНХС-ийн санхүүжилт үлэмж буурсантай холбоотойгоор иргэдийн ОНХС-ийн хэлэлцүүлэгт оролцох, саналаа өгөх сонирхол буурах<br>- ИНБ-уудыг улс төржүүлэх эрсдэл.</td><td>Үр дүнгийн тодорхойлолт 2<br><br>ЗГҮАХ 5.1.4. Зөвлөлдөх ардчилал, иргэдийн оролцоог дэмжих “Ардын засаглал” хөтөлбөр хэрэгжүүлнэ.<br><br>Улсын түвшний үзүүлэлтүүд:<br><br>19. Дуу хоолой ба хариуцлагатай байдал<br>( Эх сурвалж: ДБГ)<br><br>20. Төр засгийн бодлогын ил тод байдал<br>(Эх сурвалж: Дэлхий нийтийн өрсөлдөх чадварын тайлан)</td></tr>
<tr><td colspan="3">(4) Үйл ажиллагааны чиглэл (Швейцарын хөтөлбөр)</td></tr>
<tr><td colspan="3">Үр дүн 1:<br>• Хөдөө орон нутаг, хот суурин, хотын захын гэр хороололлуудад тодорхой салбарын (ус, эрчим хүчний үр ашиг, газар зохион байгуулалт) засаглалыг сайжруулах замаар Засгийн газрын төвлөрлийг сааруулах шинэтгэлийн хөтөлбөрийг дэмжих;<br>• ИТХ-ын төлөөлөгчид, төрийн албан хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт явуулах, институцжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;<br>• Төсөв санхүүгийн удирдлага, түүний төлөвлөлт, хяналт шинжилгээний үр ашиг, үр дүнг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;<br>• Эмэгтэй улс төрчдийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлж шийдвэр гаргалт дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх;<br>• Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хохирогчдод иж бүрэн тусламж үзүүлэх зэргээр жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлэх.<br><br>Үр дүн 2:<br>• Иргэдийн оролцооны эрх зүй, зохицуулалтын орчныг сайжруулах;<br>• Холбогдох гол оролцогч талуудын чадавхыг бэхжүүлж иргэдийн оролцооны өнөөгийн эрх зүй, бодлого зохицуулалтын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;<br>• Иргэдийн оролцооны талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх;</td></tr>
</table>

- ИНБ-уудын техникийн болон зохион байгуулалтын чадавхыг бэхжүүлж, нийгмийн эгэх хариуцлагын механизмуудын хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Салбарын яам, агентлагуудын мэдээллийг ил тод болгоход дэмжлэг үзүүлэх.

**(5) Санхүүжилт, түншлэл (Швейцарын хөтөлбөр)**

Засаглалын үндсэн чиглэлийн ирэх дөрвөн жилийн нийт төсөв 25.6 сая шв.франк байна. Хэрэгжүүлэх арга хэлбэрийн хувьд төсөл хэрэгжилтийг гэрээгээр гүйцэтгүүлэх болон төслийг хамтран санхүүжүүлэх зэрэг холимог хэлбэртэй байна. Төслүүдийг төрийн байгууллагатай хамтран санхүүжүүлж, тэдний хариуцан хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэхэд анхаарч ажиллана. Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийг ШХА өөрөө хэрэгжүүлж буй загварыг энэхүү Хамтын ажиллагааны стратегийн хүрээнд хэрэгжүүлж дуусгана. Хэрэгжүүлэгч түншүүд нь СЯ, ЗГХЭГ, УИХ-ын Тамгын газар, Нийслэлийн ЗДТГ, ХЗДХЯ, Удирдлагын академи, ДБГ, НҮБХХ, НҮБХАС, Азийн сан, ГОУХАН байна.

**(6) Удирдлагын үйл ажиллагааны үр дүн, үзүүлэлтүүд (Швейцарын хөтөлбөр)**

**Гүйцэтгэлийн үр дүн 1: Швейцарын хөтөлбөрийг нэгтгэн, бататгана; Тогтвортой байдлыг хангах үүднээс үр дүн, тэргүүн туршлагын хамрах хүрээг тэлж, бусад газарт түгээн дэлгэрүүлнэ.**

- Гол төслүүдийн (ТБУТ, Ногоон алт, МБС) холбогдох талуудад хүлээлгэн өгөх, төслийн төгсгөлийн стратегийг баталж хэрэгжүүлнэ.
- Төслийн сайн туршлагыг бататган, түгээн дэлгэрүүлэх ажлыг гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хэмжээнд институцжүүлэх, ялангуяа чадавхыг бэхжүүлэх ажлыг хөхиүлэн дэмжинэ.
- Дотоодын түншүүдийн санхүү, хүний нөөцийг нэмэгдүүлнэ.
- Төрийн байгууллагатай хамтран санхүүжүүлэх боломжийг аль болох нэмэгдүүлнэ.
- Бодлогын яриа хэлэлцээрийг нотолгоонд тулгуурлан, системтэй явуулна.
- Хандивлагчдын үйл ажиллагааг уялдаа холбоог сайжруулахад ШХА идэвхтэй үүрэг гүйцэтгэнэ.
- Үндсэн чиглэл хоорондын болон үндсэн чиглэл доторх харилцан уялдааг хөхиүлэн дэмжинэ.

**Гүйцэтгэлийн үр дүн 2: Швейцарын оролцоо, үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлтөд бэлтгэнэ**

- Ус, уур амьсгалын асуудлаарх дэлхий нийтийн хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах төслүүдийг баталж хэрэгжүүлнэ.
- Хамтын ажиллагааны шинэ хэлбэр, арга хэрэгслүүдийг (гурван талт хамтын ажиллагаа, хувийн хэвшлийг татан оролцуулах гэх мэт) туршин нэвтрүүлж, амжилттай хэрэгжсэн туршилтыг түгээн дэлгэрүүлнэ.
- Техникийн туслалцаа, мэдлэг шилжүүлэх хэлбэрт илүүтэй анхаарна.
- Нийслэлийн гэр хороололд үйл ажиллагаа явуулах боломжуудыг эрэлхийлнэ.
- Сонгосон тодорхой чиглэлээр түлхүү ажиллаж, засаглал, дэлхийн нийтийн тулгамдсан асуудлуудад гол анхаарлаа хандуулна.
- Бүх төслийн боловсруулалт, хэрэгжилт, хяналтад тэгш оролцоог хангах, ядуурлыг бууруулах шалгуур тавина.
- Бодлогын яриа хэлэлцээрт ядуурал, жендэр, тэгш оролцоог хангах явдлыг системтэйгээр оруулна.

# Хавсралт 3: Үзүүлэлтүүдийн тайлбар

| Үзүүлэлт 1 | Үндэсний хэмжээнд боловсруулсан бодлого, хууль тогтоомж, стратеги, төлөвлөгөөний тоо (Нэгдсэн жишиг шалгуур үзүүлэлтүүд (НЖШҮ-FS2) | Улсын түвшний үзүүлэлт 1 | Амины малын тоо |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Хөдөө аж ахуйтай холбоотой асуудлаарх (бэлчээр хамгаалалт, малын эрүүл мэнд, хоршоод, үр, сорт гэх мэт) хууль тогтоомж, бодлого, стратеги, төлөвлөгөөг шинэчилсэн байх | **Тодорхойлолт** | Хувийн эзэмшлийн малын бодит тоо, улсын дүнгээр |
| **Суурь үзүүлэлт** | 1 (2017) | **Суурь үзүүлэлт** | 60.5 сая толгой (2016) |
| **Зорилт** | 4 | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | Үндэсний хууль тогтоомжийн бүртгэл www.legalinfo.mn | **Эх сурвалж** | ҮСГ |
| **Цуглуулах арга** | Хууль тогтоомж, бодлого, стратеги, төлөвлөгөөний судалгаа | **Цуглуулах арга** | ҮСГ-ын аргачлал |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| Үзүүлэлт 2 | Орон нутгийн удирдлагын баталсан бэлчээр ашиглалтын гэрээний тоо | Улсын түвшний үзүүлэлт 2 | Бэлчээрийн доройтлын хувь |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Үндэсний мэдээллийн санд бүртгэгдсэн Бэлчээр ашиглалтын гэрээ (БАГ)-ний тоо, аймгийн дүнгээр | **Тодорхойлолт** | Улсын хэмжээнд тухайн экологийн бүсийг төлөөлөх ургамлын төрөл зүйлийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөнөөс доройтсон бэлчээрийн хувь, улсын дүнгээр |
| **Суурь үзүүлэлт** | 700 БАГ(2017) | **Суурь үзүүлэлт** | 65% (2015) |
| **Зорилт** | 1100 БАГ (2020) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | Ногоон алт төсөл | **Эх сурвалж** | ЦУОШГ |
| **Цуглуулах арга** | Төсөл/ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын мэдээллийн сан | **Цуглуулах арга** | 1500 ажиглалтын талбай |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Хоёр жил тутамд хэвлэгдэнэ |

| Үзүүлэлт 3 | Бэлчээрийн удирдлага, БАХ-ийн системд оруулсан төсвийн хөрөнгө оруулалтын өсөлт | Улсын түвшний үзүүлэлт 3 | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Аймгийн түвшинд бэлчээрийн удирдлагын чиглэлээр зарцуулж буй төсвийн хөрөнгө оруулалтад гарсан өөрчлөлт | **Тодорхойлолт** | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын үйлдвэрлэлийн үндэсний Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь |
| **Суурь үзүүлэлт** | Тодорхойлох | **Суурь үзүүлэлт** | 10.7% (2015) |
| **Зорилт** | + 20% (2020) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | Ногоон алт төсөл | **Эх сурвалж** | ҮСГ |
| **Цуглуулах арга** | Төслүүд | **Цуглуулах арга** | ҮСГ-ын аргачлал |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| Үзүүлэлт 4 | Орлого нь нэмэгдсэн (эрэгтэй/эмэгтэй) малчид, өрхийн тариаланчдын тоо | Улсын түвшний үзүүлэлт 4 | Хөдөө аж ахуйн салбарт хоршоодын эзэмшиж буй хөрөнгийн хэмжээ, гишүүдийн тоо |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Өмнөх тайлангийн үетэй харьцуулахад нэг гишүүнд ноогдох борлуулалтын орлогоо өсгөсөн хоршооны гишүүн малчин, тариаланчдын тоо | **Тодорхойлолт** | Хөдөө аж ахуйн салбарын хоршоодын эзэмшил хөрөнгийн нийт хэмжээ (төгрөгөөр), ҮСГ-ын аж ахуйн нэгжийн бүртгэлд бүртгэгдсэн нийт гишүүдийн тоо |
| **Суурь үзүүлэлт** | Байхгүй | **Суурь үзүүлэлт** | 12,359.8 сая төгрөг<br>17,026 гишүүн (2015) |
| **Зорилт** | 2017 оны жилийн эцэст тодорхойлогдоно | **Зорилт** | Байхгүй |

| | | | |
|---|---|---|---|
| **Эх сурвалж** | Ногоон алт төсөл | **Эх сурвалж** | ҮСГ |
| **Цуглуулах арга** | Хоршоодын данс бүртгэл | **Цуглуулах арга** | ҮСГ-ын аргачлал |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 5** | **Дэмжлэг үзүүлсэн хоршоодын борлуулалтын өсөлт** | **Улсын түвшний үзүүлэлт 5** | **Малын гаралтай бүтээгдэхүүний экспорт (түүхий ноолуур, боловсруулсан мах)** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Дэмжлэг үзүүлсэн хоршоодын нийт борлуулалтын хэмжээнд өмнөх тайлангийн үетэй харьцуулахад гарсан өөрчлөлт | **Тодорхойлолт** | Түүхий ноолуур, боловсруулсан махны экспортын хэмжээ, тонноор |
| **Суурь үзүүлэлт** | 2017 оны жилийн эцэст тодорхойлогдоно | **Суурь үзүүлэлт** | Түүхий ноолуур: 4,988 тонн Боловсруулсан мах: 4.7 мянган тонн (2015) |
| **Зорилт** | +30% (2020) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | Монгол ногоо төсөл, Ногоон алт төсөл | **Эх сурвалж** | ҮСГ |
| **Цуглуулах арга** | Төсөл | **Цуглуулах арга** | ҮСГ-ын аргачлал |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 6** | **Дотоодын зах зээл дээр байгаа хүнсний ногооны батлагдсан сортын тоо** | **Улсын түвшний үзүүлэлт 6** | **Хүнсний ногооны ургац, улсын дундаж (тонн/га)** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Улсын сорт сорилтын зөвлөлөөс баталсан дотоодын зах зээлд байгаа хүнсний ногооны сорт | **Тодорхойлолт** | Хүнсний ногооны нэг га-гийн дундаж ургац, тонноор |
| **Суурь үзүүлэлт** | 2 (2017) | **Суурь үзүүлэлт** | 9.4 мянган тонн/га (2015) |
| **Зорилт** | 8 (2019) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | Монгол ногоо төсөл | **Эх сурвалж** | ҮСГ |
| **Цуглуулах арга** | Улсын сорт сорилтын зөвлөлийн товч мэдээлэл | **Цуглуулах арга** | ҮСГ-ын аргачлал |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 7** | **Эмэгтэй даргатай БАХ, хоршоодын эзлэх хувь** | **Улсын түвшний үзүүлэлт 7** | **Нэг хүнд ногдох хүнсний ногооны хэрэглээ, улсын дундаж (кг)** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Төслийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан, эмэгтэй даргатай БАХ, хоршоодын эзлэх хувь | **Тодорхойлолт** | Хүнсний ногооны нэг хүний нэг жилийн хэрэглээ, кг-аар |
| **Суурь үзүүлэлт** | 27% (2017) | **Суурь үзүүлэлт** | 58 кг (2015) |
| **Зорилт** | 35% (2020) | **Зорилт** | 70 кг (2020) |
| **Эх сурвалж** | Ногоон алт төсөл, Монгол ногоо төсөл | **Эх сурвалж** | ҮСГ |
| **Цуглуулах арга** | Төсөл | **Цуглуулах арга** | ҮСГ-ын аргачлал |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 8** | **ШХА-ын төслүүдийн бодитой хувь нэмэр орж батлагдсан бодлогын баримт бичиг, зохицуулалтын тоо** | **Улсын түвшний үзүүлэлт 8** | **Тогтвортой хөгжил, ерөнхий ба мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн салбарын талаарх шинэ ба шинэчилсэн бодлогын тоо** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | ТХБ-ын хэрэглээг дэмжих, техник мэргэжлийн боловсролын чанар, залуучуудын ажил эрхлэлтийг сайжруулах чиглэлээр гаргасан бодлогын баримт бичгийн (УИХ, Засгийн газраас баталсан хууль тогтоомж, төрийн бодлого, зохицуулалтын) нийт тоо | **Тодорхойлолт** | ТХБ, тогтвортой хөгжил, ногоон хөгжил болон МБС, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр УИХ, Засгийн газраас батлан гаргасан нийт хууль тогтоомж, төрийн бодлого, зохицуулалтын тоо |
| **Суурь үзүүлэлт** | 3 (2016) | **Суурь үзүүлэлт** | тодорхойлох |

| | | | |
|---|---|---|---|
| **Зорилт** | 8 (2020) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | ТХБТ, МУЧХТ, ЗХЭДТ | **Эх сурвалж** | БСШУСЯ, ХНХЯ |
| **Цуглуулах арга** | Төслийн тайлан | **Цуглуулах арга** | Салбарын судалгаа, дүн шинжилгээ |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 9** | **ТХБ болон мэргэжлийн боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан (эрэгтэй, эмэгтэй) багш, сургагч нарын тоо (НЖШҮ-EV2)** | **Улсын түвшний үзүүлэлт 9** | **Ерөнхий болон мэргэжлийн боловсролын сургуулиудын орон тооны (эрэгтэй, эмэгтэй) багш нарын тоо** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | ТХБ-ыг нэвтрүүлсэн хөтөлбөрт хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн (эрэгтэй, эмэгтэй) багш, сургагч нарын нийт тоо; мэргэжлийн боловсролын шинэчлэгдсэн, мэргэжил дээшлүүлэх сургалт, хичээлд хамрагдсан багш, сургагч нарын (үйлдвэрийн дадлагажуулагч багш нарын) нийт тоо | **Тодорхойлолт** | Ерөнхий боловсролын сургуулиуд, ТМБС-ын төвүүдийн орон тооны багш нарын тоо |
| **Суурь үзүүлэлт** | ТХБТ: 21,600 (2016)<br>МУЧХТ: 848 (2016) | **Суурь үзүүлэлт** | Нийт 30,994 (эмэгтэй 24’741)<br>ЕБС: 28,490 (81% нь эмэгтэй);<br>ТМБС: 2,504 (65% нь эмэгтэй) |
| **Зорилт** | ТХБТ: ахисан түвшний сургалт 2,500 (2020)<br>МУЧХТ: +10% (2019) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | ТХБТ, МУЧХТ | **Эх сурвалж** | ҮСГ |
| **Цуглуулах арга** | Төслийн тайлан | **Цуглуулах арга** | ҮСГ-ын аргачлал |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 10** | **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, тэдний эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэх талаарх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн байдал** | **Улсын түвшний үзүүлэлт 10** | **Шинээр ажилд оруулсан хүний тоо** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Үйлчилгээ авсандаа сэтгэл ханамжтай байгаа үйлчлүүлэгчдийн эзлэх хувь | **Тодорхойлолт** | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдаж ажилтай болсон үйлчлүүлэгчийн тоо |
| **Суурь үзүүлэлт** | Суурь үзүүлэлт байхгүй | **Суурь үзүүлэлт** | 32,219 (2015) |
| **Зорилт** | 80% (2019) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | ЗХЭДТ, ХНХЯ-тай хамтран | **Эх сурвалж** | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ) |
| **Цуглуулах арга** | Үнэлгээний маягтууд | **Цуглуулах арга** | ХХҮЕГ-ын ажиллах хүчний судалгааны аргачлал |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 11** | **Мэргэжлийн ур чадвар олгох сургалтад хамрагдсан, ТХБ-ыг хэрэгжүүлсэн хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн тоо (НЖШҮ-EV3)** | **Улсын түвшний үзүүлэлт 11** | **Тухайн хичээлийн жилд МБС-д хамрагдсан (эрэгтэй, эмэгтэй) оюутны тоо** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | i) МУЧХТ-ийн зорилтот мэргэжлээр суралцагчид;<br>ii) Ур чадварын сургалтад хамрагдсан насанд хүрэгчид;<br>iii) ТХБ хэрэглэж буй ерөнхий боловсролын сургуулийн сурагчид | **Тодорхойлолт** | МСҮТ-ийн оюутнуудын үнэмлэхүй тоо |
| **Суурь үзүүлэлт** | Зорилтот мэргэжлээр | **Суурь үзүүлэлт** | 42’675 (2015) |

| | | | |
|---|---|---|---|
| | суралцагчид: 754;<br>Ур чадварын богино хугацааны сургалтад хамрагдсан насанд хүрэгчдийн тоо: 1403;<br>ТХБ: улсын хэмжээгээр 300,000 орчим сурагч (2016) | | |
| **Зорилт** | МУЧХТ: + 20% (2019)<br>ТХБ: улсын хэмжээгээр 500,000 орчим оюутан | **Зорилт** | 2020: 60,000 |
| **Эх сурвалж** | МУЧХТ, ТХБТ | **Эх сурвалж** | ҮСГ |
| **Цуглуулах арга** | Төслийн тайлан | **Цуглуулах арга** | ҮСГ-ын аргачлал |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 12** | **Ажил эрхлэлтийн боломжоо дээшлүүлсэн залуучууд, насанд хүрэгчдийн (эрэгтэй, эмэгтэй) эзлэх хувь** | **Улсын түвшний үзүүлэлт 12** | **Ажилгүйдлийн түвшин (эрэгтэй, эмэгтэй)** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Сургалтад хамрагдсанаас хойш 6 сарын дотор ажилд орсон (хөдөлмөр эрхлэгчийн хөдөлмөрийн хөлс цалингийн доод түвшнээс 10% өндөр байх) эсвэл үргэлжлүүлэн суралцаж байгаа төгсөгчдийн эзлэх хувь | **Тодорхойлолт** | Хөдөлмөрийн насны хүн амд ажилгүй иргэдийн эзлэх хувь |
| **Суурь үзүүлэлт** | 34% (эмэгтэй 16%) (2016) | **Суурь үзүүлэлт** | 7.5% (2015, ҮСГ) |
| **Зорилт** | 60% (эмэгтэй 20%) (2019) | **Зорилт** | 2020: 6% (МУЗГ-ын зорилт) |
| **Эх сурвалж** | МУЧХТ | **Эх сурвалж** | ҮСГ |
| **Цуглуулах арга** | Төгсөлтийн дараах 6 сард явуулах мөшгих судалгаа | **Цуглуулах арга** | ҮСГ-ын аргачлал |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 13** | **Хувийн хэвшил ба сургуулиудын (ерөнхий ба техник мэргэжлийн) хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний тоо** | **Улсын түвшний үзүүлэлт 13** | **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн жилийн нийт санхүүжилт (төгрөгөөр)** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Хувийн хэвшил, техник мэргэжлийн сургуулиудын хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний тоо;<br>Хувийн хэвшил, ерөнхий боловсролын сургуулиудын хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний тоо | **Тодорхойлолт** | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд зориулж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон санхүүжилтийн хэмжээ |
| **Суурь үзүүлэлт** | МУЧХТ: 28 (2016)<br>ТХБ: 0 | **Суурь үзүүлэлт** | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрт зориулж 26,665 сая төгрөг |
| **Зорилт** | МУЧХТ: 56 (2019)<br>ТХБ: 40 (2020) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | ТХБ, МУЧХТ | **Эх сурвалж** | ХНХЯ |
| **Цуглуулах арга** | Төслийн тайлан | **Цуглуулах арга** | Салбарын тайлан |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 14** | **Төгсөгчдийн (эрэгтэй, эмэгтэй) мэдлэг боловсрол, ур чадварын талаарх ажил олгогчдын сэтгэл ханамжийн байдал** | **Улсын түвшний үзүүлэлт 14** | **Залуучуудын ажилгүйдлийн түвшин (эрэгтэй, эмэгтэй)** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Сургуулиудтай хамтран ажиллаж, тухайн мэргэжлийн боловсролын сургалтууд агуулга, зохион байгуулалтын хувьд тэдний хэрэгцээнд нийцэж байна гэж хариулсан ажил олгогчдын эзлэх хувь | **Тодорхойлолт** | Нийт ажиллах хүчинд 15-24 насны залуучуудын эзлэх хувь |

| | | | |
|---|---|---|---|
| **Суурь үзүүлэлт** | 53% (2016) | **Суурь үзүүлэлт** | 17.4% (2014) |
| **Зорилт** | 65% (2019) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | МУЧХТ | **Эх сурвалж** | ОУХБ |
| **Цуглуулах арга** | Төслийн тайлан (судалгаа) | **Цуглуулах арга** | ОУХБ, СТАТ мэдээллийн сан |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 15** | **ИТХ-ын үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ** | **Улсын түвшний үзүүлэлт 15** | **Орон нутгийн төсвийн зарцуулалт** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | ИТХ-ын үйл ажиллагааг “сайн”, “маш сайн” гэж үнэлсэн иргэдийн эзлэх хувь | **Тодорхойлолт** | Нэгдсэн төсвийн нийт зарлагад орон нутгийн төсвийн зарлагын эзлэх хувь |
| **Суурь үзүүлэлт** | Улаанбаатарт 18.4%;<br>Хөдөөд 27.3% (2015) | **Суурь үзүүлэлт** | 2015: 29% |
| **Зорилт** | Уланбаатарт 30%;<br>Хөдөөд 40% (2019) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | ТББ Төсөл | **Эх сурвалж** | ҮСГ |
| **Цуглуулах арга** | Олон нийтийн санал асуулга | **Цуглуулах арга** | Монгол Улсын статистикийн эмхэтгэл |
| **Давтамж** | 3 жил тутамд | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 16** | **Сумын захиргаадын жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл** | **Улсын түвшний үзүүлэлт 16** | **Засгийн газрын үргүй зардал** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | 8 үндсэн шалгуур үзүүлэлтэд үндэслэн тооцсон жилийн үйл ажиллагааны үнэлгээний дундаж оноо | **Тодорхойлолт** | Засгийн газрын үргүй зардлын түвшинд 1-7 оноо өгч, дэлхийн 144 орныг онооны дараалаар эрэмбэлдэг |
| **Суурь үзүүлэлт** | 31.4% (2016) | **Суурь үзүүлэлт** | Оноо 3.3, дэлхийн 144 орноос 120 дугаар байр бичигдсэн (2015-2016) |
| **Зорилт** | 40% (2017)<br>50% (2018)<br>60% (2019) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | СЯ | **Эх сурвалж** | Дэлхий нийтийн өрсөлдөх чадварын тайлан |
| **Цуглуулах арга** | СЯ, Сумдын үйл ажиллагааны жилийн үнэлгээ | **Цуглуулах арга** | Эдийн засгийн өрсөлдөх чадварын үнэлгээ |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 17** | **Жендэр- УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл (НЖШҮ-G3)** | **Улсын түвшний үзүүлэлт 17** | **Засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөөтэй байдал** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | УИХ болон орон нутгийн сонгуульт байгууллагад сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь | **Тодорхойлолт** | Төрийн үйлчилгээний болон төрийн албаны чанарын тухай ойлголт мэдлэг |
| **Суурь үзүүлэлт** | Улсын түвшинд 14.5%<br>Орон нутгийн түвшинд 27.3% (2015) | **Суурь үзүүлэлт** | Утга -0.40; нийт 214 орноос 40 дүгээр байрт бичигдсэн (2015-2016) |
| **Зорилт** | Улсын түвшинд 30%<br>Орон нутгийн түвшинд 40% | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | Сонгуулийн албан ёсны үр дүн | **Эх сурвалж** | ДБГ |
| **Цуглуулах арга** | Сонгуулийн албан ёсны үр дүн | **Цуглуулах арга** | Дэлхий дахины засаглалын үзүүлэлтүүд (ДДЗҮ) |
| **Давтамж** | 4 жил тутамд | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 18** | **Бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл (НЖШҮ-G1)** | **Улсын түвшний үзүүлэлт 18** | **Жендэрт суурилсан хүчирхиийлэлд өртөгсдийг хамгаалах байрны тоо** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Бие, сэтгэлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөний улмаас хохирогчдод туслах Нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд (НЦҮТ-үүд) ирж сэтгэл зүй, эрүүл мэнд, эрх | **Тодорхойлолт** | Хүчирхийлэлд өртөгсдөд зориулж аймаг, хот, дүүргийн түвшинд байгуулсан хамгаалах байрны тоо |

| | | | |
|---|---|---|---|
| | зүйн тусламж үйлчилгээ авсан (эрэгтэй, эмэгтэй) хүний тоо | | |
| **Суурь үзүүлэлт** | Үндэсний судалгааны дараа тодорхойлох | **Суурь үзүүлэлт** | 2015 онд 10 |
| **Зорилт** | Тодорхойлох | **Зорилт** | 2019 онд 20<br>2021 онд 30 |
| **Эх сурвалж** | ЖСХТТ | **Эх сурвалж** | Үзүүлэлт 12 (Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр 2017-2021) |
| **Цуглуулах арга** | ЭМЯ, ХЗДХЯ-нны тайлан, ЖСХ-ийн мэдээллийн нэгдсэн сан, НЦҮТ-үүд | **Цуглуулах арга** | ХЗДХЯ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, СЯ, Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо, орон нутгийн захиргаад, орон н утгийн хурлууд, ТББ-уудын тайлан, шийдвэрүүд |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 19** | **Сумдын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд багуудын тэргүүлэх чиглэлийг тусгасан байдал (НЖШҮ-GO1)** | **Улсын түвшний үзүүлэлт 19** | **Дуу хоолой ба хариуцлагатай байдал** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Сумдын хөрөнгө оруулалтын шийдвэрт багийн иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг тусгасан сумдын эзлэх хувь | **Тодорхойлолт** | Аливаа улсын иргэдэд төр засгаа сонгоход оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, чөлөөтэй хэвлэн нийтлэх эрх чөлөө хэр их байгааг тухай ойлголтын түвшин |
| **Суурь үзүүлэлт** | Улсын дундаж 39%<br>Хамгийн шилдэг аймаг 100%, хамгийн муу аймаг 0% (2016) | **Суурь үзүүлэлт** | Утга -0.24, нийт 214 улсаас 56 дугаарт эрэмблэгдсэн байна (2015-2016) |
| **Зорилт** | 50% (2017)<br>55% (2018)<br>60% (2019) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | СЯ-ны Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, Үзүүлэлт 10 | **Эх сурвалж** | ДБГ |
| **Цуглуулах арга** | СЯ, ТА- 3 төсөл | **Цуглуулах арга** | ДДЗҮ |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

| **Үзүүлэлт 20** | **Идэвхтэй үйл ажиллагаатай ИНБ-ын дотор нийгмийн эгэх хариуцлагын төсөл хэрэгжүүлэх чадвартай нь нотлогдсон ИНБ-ын эзлэх хувь** | **Улсын түвшний үзүүлэлт 20** | **Төр засгийн бодлогын ил тод байдал** |
|---|---|---|---|
| **Тодорхойлолт** | Нийгмийн эгэх хариуцлагын төсөл хэрэгжүүлсэн туршлагатай ИНБ-уудын нийт ИНБ-д эзлэх хувь | **Тодорхойлолт** | Төр засгийн ил тод байдалд 1-7 оноо өгч, дэлхийн 144 улсыг онооны дараалаар эрэмбэлдэг |
| **Суурь үзүүлэлт** | Нийт ИНБ-ын 44.2% нь нийгмийн эгэх хариуцлагын төсөл хэрэгжүүлж байсан туршлагатай (2016) | **Суурь үзүүлэлт** | Оноо 4.1, нийт 144 улсаас 69 дүгээрт эрэмблэгдсэн (2015-2016) |
| **Зорилт** | Нийт ИНБ-ын 50% нь нийгмийн эгэх хариуцлагын төсөл хэрэгжүүлж байсан туршлагатай (2019) | **Зорилт** | Байхгүй |
| **Эх сурвалж** | МУНЭХБТ | **Эх сурвалж** | Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан |
| **Цуглуулах арга** | ИНБ-уудын үнэлгээ, төслүүдийн жилийн тайлан | **Цуглуулах арга** | Эдийн засгийн өрсөлдөх чадварын үнэлгээ |
| **Давтамж** | Жил бүр | **Давтамж** | Жил бүр |

# Хавсралт 4: Хяналт үнэлгээний систем

| Хэмжээс | Хяналт тавих чиглэл | Арга хэрэгсэл | Давтамж |
|---|---|---|---|
| **Улс орны нөхцөл байдал** | Хамтын ажиллагааны стратегитай холбоотой улс орны ерөнхий нөхцөл байдал | Дотоод хяналт, ажиллалтын MERV систем | Жил бүр: 9 дүгээр сар |
| **Швейцарын хөтөлбөрийн багц** | • Швейцарын хөтөлбөрийн үнэлгээ<br>• Улс орны хөгжлийн үр дүн<br>• Нийтлэг үйлчлэх сэдвүүд | Үндсэн чиглэлийн улирлын тайлан | Улирал бүр: 3, 6, 9-р сарууддад (Жилийн тайлан), 1-р сар (Оны төлөвлөлтийн хурал) |
| | | Түншүүдтэй хамтарсан жилийн хөтөлбөрийн үнэлгээ | Жил бүр: 9 дүгээр сар |
| | | Хяналт шинжилгээний матриц | Жил бүр: 9 дүгээр сар |
| | | Жилийн тайлан | Жил бүр: 10 дугаар сар |
| | | Стратегийн дунд хугацааны үнэлгээ | Стратеги бүрт нэг удаа: 2019 оны намар |
| | | Төслийн үнэлгээнүүд | Төслийн үе шат бүрт нэг удаа (дунд хугацааны эсвэл төгсгөлийн үнэлгээ) |
| **Удирдлага** | Швейцарын Хамтын ажиллагааны газрын үйл ажиллагааны үр ашигтай байдал, дүрэм журмын хэрэгжилт | Дотоод хяналтын системийн тайлан | Жил бүр: 9 дүгээр сар |
| | | Хөндлөнгийн аудит | Жил бүр: 3-4 дүгээр сар |

# Хавсралт 5: Санхүүгийн төлөвлөлт

**Төлөвлөсөн санхүүжилт** (сая шв.франкаар, тоймлосон тоо)

| Үндсэн чиглэл | 2018 | 2019 | 2020 | 2021 | Нийт | % |
|---|---|---|---|---|---|---|
| Засаглал | 3.9 | 6.3 | 7.7 | 7.7 | **25.6** | 50% |
| Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал | 3.9 | 2.8 | 2.2 | 2.2 | **11.1** | 22% |
| Суурь боловсрол, мэргэжлийн сургалт | 3.7 | 2.6 | 1.6 | 1.6 | **9.5** | 18% |
| Бусад төсөл | 2.0 | 1.8 | 1.0 | 0.5 | **5.3** | 10% |
| **Жилийн нийт дүн** | **13.5** | **13.5** | **12.5** | **12.0** | **51.5** | 100% |

# Хавсралт 6: Нэр томъёо

| | |
|---|---|
| Аймаг | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж (нийт 21 аймагтай) |
| Баг | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгж (*сум* нь багуудад хуваагддаг) |
| Хурал | Үндэсний хэмжээний (Улсын Их Хурал) болон нутгийн өөрөө удирдах байгууллага (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал) |
| Сум | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж (*аймгууд* сумдад хуваагддаг) |

# Хавсралт 7: Монгол Улсын газрын зураг





**Хэвлэл:**

**Хянан тохиолдуулсан:**
Швейцарын Холбооны Гадаад хэргийн яам
**Швейцарын хөгжлийн агентлаг**
Берн хот 3003
Швейцар
www.fdfa.admin.ch/sdc

**Эх бэлтгэл:**
ШХА-ийн График дизайн, хэвлэлийн алба

**Зураг:**
Монгол дахь Швейцарын хамтын ажиллагааны газар

**Захиалах:**
www.sdc.admin.ch/publications

**Холбоо барих:**
Швейцарын хөгжлийн агентлаг
Өмнөдийн хамтын ажиллагааны газар
Зүүн Азийг хариуцсан хэлтэс
Фрайбург гудамж 130
Берн хот 3003
Швейцар

Утас: +41 (0)58 462 34 75, Fax: +41 (0)58 465 93 57
www.sdc.admin.ch

Берн, 2017 оны 12-р сар